

ЗӨВШӨӨРСӨН:  
ЭМНЭЛГИЙН МЭРТЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

*Ц. Эрдэмбилэг*  
Ц. ЭРДЭМБИЛЭГ



БАТЛАВ:  
ЧИХ ХАМАР ХООЛОЙ СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

*Ө. Жаргалхүү*  
Ө. ЖАРГАЛХҮҮ



**ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“ЧИХ ХАМАР ХООЛОЙ СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**ИНДЕКС:** S(r) 091218

**ХУГАЦАА:** 2 жил /88 кредит/

**УЛААНБААТАР ХОТ  
2022 он**

**Боловсруулсан ажлын хэсэг:**

Э.Жаргалхүү	Монгол Улсын Зөвлөх эмч, Анагаах ухааны доктор, дэд профессор
Л.Бямбасүрэн	Монгол Улсын Зөвлөх эмч, Анагаах ухааны доктор
М.Заяа	Анагаах ухааны доктор, дэд профессор
С.Бямбасүрэн	Монгол Улсын Зөвлөх эмч, анагаах ухааны магистр
Б.Дэлгэрмаа	Монгол Улсын Зөвлөх эмч, анагаах ухааны магистр
Хан Ён Хүнь	Анагаах ухааны магистр

**Хамтран ажилласан:**

Г.Уянга	Чих, хамар, хоолойн ахлах зэргийн эмч, Анагаах ухааны магистр
Э.Золцэцэг	Чих, хамар, хоолойн ахлах зэргийн эмч, Анагаах ухааны магистр
Н. Мягмарнаран	Чих, хамар, хоолойн мэс заслын эмч, Анагаах ухааны магистр

**Хянасан:**

Эрүүл Мэндийн Яамны Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга

АШУҮИС-н Төгсөлтийн дараах сургалт, хөтөлбөрийн дэд хороо

## ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

### **Хөтөлбөрийн нэр /монгол, англи хэлээр/**

Чих хамар хоолой судлал ба толгой хүзүүний мэс засал  
Otorhinolaryngology & Head and Neck Surgery

### **Мэргэшлийн индекс**

S(r) 0912-Чих хамар хоолойн эмч (Otorhinolaryngologist)

### **Элсэгчдийн боловсролын түвшин**

Бакалавр, хүний их эмч

### **Сургалтын төрөл**

Мэргэшүүлэх сургалт

### **Сургалтын хэлбэр**

Өдөр

### **Сургалтын хугацаа**

24 сар

### **Нийт багц цаг**

88 кредит

### **Эрх зүйн зохицуулалт:**

- Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль;
- Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль;
- Монгол Улсын Эмнэлгийн тусламжийн тухай хууль;
- ЭМСайдын 2016 оны А/184 дүгээр “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаал;
- ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” 2017 оны А/337 дугаар тушаал;
- ЭМС-ын 2018 оны А/427 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал;

**Мэргэжлийн тодорхойлолт:** Чих хамар хоолойн эмч нь чих хамар хоолой ба толгой хүзүүний бүтэц үйл ажиллагаа, насны онцлог, өсөлт хөгжил, эрүүл ба эмгэг байдлыг үнэлэх, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар онолын өндөр мэдлэгтэй, мэс ажилбар ба мэс засалд дадлагажсан, эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ойлгож, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан, инноваци бүхий мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн, бүх шатлалын эмнэлэгт чих хамар хоолойн эмчээр ажиллаж чадах мэргэжилтэн байна.

## ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ЧИХ ХАМАР ХООЛОЙ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### Нэг. Үндэслэл

ДЭМБ-ийн 2010 оны судалгаагаар 10000 хүн тутмын 1860 нь чих хамар хоолойн эмгэгээр өвдөж байгаа бөгөөд нийгмийн хөгжил, хүн амын өсөлт, хүрээлэн байгаа орчны нөлөөлөл, амьдралын хэв маягаас шалтгаалан өвчлөл улам ихсэх хандлагатай байгааг тэмдэглэсэн байна. Өвчлөл, нас баралтын гол шалтгаан болсон халдварт бус өвчнүүд олон улсын хэмжээнд жилээс жилд өсч, хотжилт, хүн амын нягтрал, орчны болон агаарын бохирдол, амьдралын буруу хэвшил нь хүний эрүүл мэндэд ихээхэн нөлөөлж, халдварт бус өвчний эрсдлийг улам нэмэгдүүлж байна.

Л.Шагдар, Б.Эрдэнэчулуун (1999) нарын судалгаагаар Монгол улсад 1000 хүн тутмын 568 нь чих хамар хоолойн эмгэгээр өвдөж байгаа ба 10000 шинэ төрөлт тутамд тохиолдох чих, хамар, хоолой эрхтний төрөлхийн гажигийн тоо ихсэж байгаа нь чих хамар хоолойн эмгэгийн оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт болон чих хамар хоолойн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нэн чухал асуудлын нэг хэвээр байна.

Монгол орны газар зүйн байршил, хүн ам, цаг уурын онцлогоос шалтгаалан амьсгалын дээд замын эмгэг тодорхой хэмжээгээр буурахгүй байгаа ба Монгол улсын хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн 54.7%, хүүхэд өсвөр насны өвчлөлийн 10.000 хүүхэд тутмын 25.0%, хэвтэн эмчлүүлэгч насанд хүрэгчдийн 15.7%-ийг тус тус амьсгалын дээд замын өвчлөл эзэлж байгаа ба 2017 оны Монгол улсын ЭМЯ-ны мэдээллээр амьсгалын тогтолцооны эмгэг нь хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд орж байгаа бөгөөд 10000 хүн ам тутамд 1671.4 хүн амьсгалын дээд замын өвчнөөр өвдөж, 10000 хүн ам тутамд 431.9 хүн хэвтэн эмчлүүлсэн байна.

ДЭМБ-ын 2017 оны тайланд эмнэлгийн яаралтай тусламжийн 22%-ийг чих, хамар, хоолойн өвчлөл эзэлж байгаа бөгөөд дэлхийн хүн амын 30% нь чих хамар хоолойн эмгэгээр өвчилж, ялангуяа хөгжиж байгаа орны иргэдийн дунд чих, хамар, хоолойн өвчлөл жилээс жилд нэмэгдэж байгааг тэмдэглэсэн байна.

Монгол орны цаг уурын онцлог, агаар орчны нөлөөллөөс шалтгаалан амьсгалын дээд замын эмгэг тодорхой хэмжээгээр буурахгүй байгаа ба Монгол улсын хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн 54.7%, хүүхэд өсвөр насны өвчлөлийн 10.000 хүүхэд тутмын 25.0%, хэвтэн эмчлүүлэгч насанд хүрэгчдийн 15.7%-ийг тус тус амьсгалын дээд замын өвчлөл эзэлж байна. (Монгол Улсын Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тайлан-2017он)

2019 оны байдлаар Монгол улсын эрүүлийн мэндийн салбарт 163 чих хамар хоолойн мэргэжлийн эмч нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа боловч 10000 хүн амд 0.5 чих хамар хоолойн эмч ноогдож байгаа нь хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд хангалттай бус бөгөөд Монголын чих, хамар, хоолой судлалын салбарт олон улсын жишиг эмчилгээ, оношилгооны шинэ арга, технологи хурдацтай нэвтрэхийн хэрээр өндөр төвшний мэдлэг, ур чадвар, чадамж бүхий мэргэшсэн эмч бэлтгэх хэрэгцээ нэмэгдэж байна.

Монгол улсын хүн ам эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа өнөө үед чих хамар хоолойн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд нарийн мэргэжлийн эмчийг сургалтын нэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэшүүлж, эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ойлгож, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, эмнэл зүй-эрдэм шинжилгээний хослуулсан мэргэжилтэн бэлтгэж, чих хамар хоолойн эмгэгийн оношлогоо-эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах үндэслэл болж байна.

### **Хоёр. Эрхэм зорилго**

Чих хамар хоолой-толгой-хүзүүний бүтэц, үйл ажиллагаа, шинжлэх арга, чих хамар хоолойн эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээний онол-эмнэлзүйн өндөр мэдлэгтэй, чих хамар хоолойн эмгэгүүдийн үеийн яаралтай ба нарийн мэргэжлийн тусламжийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх түвшинд үзүүлэх эмнэлзүйн чадвартай, бүх шатлалын эмнэлэгт ажиллах чадвартай чих хамар хоолойн эмчийг боловсролын үндсэн зарчим, олон улсын жишиг хандлагад нийцүүлэн бэлтгэхэд сургалтын зорилго оршино.

### **Гурав. Алсын хараа**

Эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ухарсарласан, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх онолын өндөр мэдлэгтэй, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан, инноваци бүхий мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна

### **Дөрөв. Цогц чадамж**

Чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, мэргэжлийн тусламж үйлчилгээг бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

#### **1. Чих хамар хоолой судлалын эмч байх. (*otorhinology*)**

- Чих хамар хоолойн эрхтнүүдийн эмгэгийн шинж тэмдгийг таньж, ялган оношлох
- Өвчтөнөөс асуумж авч, мэргэжлийн үзлэг хийх, тухайн үйлчлүүлэгчийн сэтгэл зүй, нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

- Тухайн эмч өөрийн ажиллаж байгаа эмнэлгийн (орон нутаг, дүүргийн эмнэлэг, төрөлжсөн, нэгдсэн, клиник) төвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдэл, ажилбарын стандарт удирдамжийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх
  - Өвчтөний хувийн нууцыг хадгалах
  - Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах
  - Тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний нөөц бололцоог бүрэн дайчилж үйлчлүүлэгчид үзүүлэх мэргэжлийн тусламж үйлчилгээг шийдвэрлэх
  - Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, тайлан, бичиг баримтыг зохих журмын дагуу цаг тухайд нь хөтлөх
- 2. Мэргэжлийн байх (*professional*)**
- Чих хамар хоолой судлалын салбарт, тухайн эрүүл мэндийн байгууллагад өөрийн мэргэжлээр хувь нэмэр оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх
  - Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж , хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
  - Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах
- 3. Суралцагч байх (*learner*)**
- Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд байнга хамрагдах
  - Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх
  - Хамтран суралцагч эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах
- 4. Харилцагч байх (*communicator*)**
- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах
  - Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах
  - Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй зөвлөлдөх
- 5. Хамтрагч байх (*collaborator*)**
- Тухайн орон нутгийн болон үйлчлэх хүрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах.
  - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах
- 6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (*community health advocate*)**

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх

#### **7. Зохион байгуулагч, манлайлагч байх (leader)**

- Мэргэжлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах

#### **Тав. Сургалтын зорилт**

Хөтөлбөр нь доорхи зорилтыг ханган биелүүлнэ:

- Хөтөлбөрийн дагуу лекц, семинари, эрдэм судлалын ажлын суурь мэдлэг болон эмнэлзүйн сургалтаар чих хамар хоолой ба толгой хүзүүний мэс заслын шинжлэх ухааны орчин үеийн мэдээллээр хангаж, мэдлэг эзэмшүүлэх
- ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлгүүдийн чих хамар хоолойн тасаг, кабинетад мэргэшсэн эмч-багшийн удирдлаган дор чих хамар хоолойн бүтэц, үйл ажиллагаа, шинжлэх аргуудын судалж, дадлагажуулан эмнэл зүйн ур чадвар эзэмшүүлэх
- Эмчлүүлэгчид хандах хандлагыг төлөвшүүлж, эмчилгээ, шинжилгээ, гардан үйлдлүүдийг эмнэлзүйн удирдамж, стандартын дагуу гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэх
- Эмчлүүлэгчид зөвлөлгөө өгөх, үнэлэх, хяналт хийх чадварыг эзэмшүүлэх
- Чих хамар хоолойн зонхилон тохиолдох ба зарим ховор эмгэгүүдийн үед хагалгааны заалтыг зөв гаргаж, мэс заслын арга барилд сургах

### **Зургаа. Сургалтын арга зүй**

#### **6.1 Сургалтын хугацаа**

- Резидент нь 2 жил буюу 4 улирал суралцаж төгсөнө. 1 улирал нь 22 долоо хоног үргэлжлэх ба нийт 88 долоо хоногийн сургалтыг дүүргэнэ.
- Тасаг/тэнхим дээр суралцаж, ажиллах хугацаандаа “Чих хамар хоолой судлалын тэнхмийн резидент эмч нар үндсэн ба түшиц эмнэлгүүдийн чих хамар хоолойн тасагт ажиллах журам” /Хавсралт 1/, “Резидент эмч нарын амралт, чөлөө, таслалт, хоцролтыг тооцох, зохицуулах журам”-ыг чих хамар хоолой судлалын тэнхмийн дотоод журмын дагуу мөрдөнө /Хавсралт 2/.

#### **6.2 Сургалтын багтаамж**

Нийт 88 багц цаг

#### **6.3 Резидентийн сургалтанд элсэгчдийн үндсэн шаардлага:**

Анагаах ухааны бакалаврын зэрэг олгох дотоод, гадаадын их, дээд сургуулийн хөтөлбөрийг бүрэн, амжилттай дүүргэсэн, хүний их эмчийн мэргэжлийн дипломтой эмчийг резидентийн сургалтанд элсүүлнэ.

#### **Элсэгчдэд тавигдах шаардлага**

- Анагаах ухааны их, дээд сургуулийг хүний их эмчийн мэргэжлээр төгссөн, бакалаврын зэрэгтэй.
- **Ерөнхий мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх**
- Чих хамар хоолой ба толгой хүзүүний мэс засалч эмчийн мэргэжилд дур сонирхолтой.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх
- Резидентийн сургалтын элсэлтийн шалгалтанд тэнцсэн байх

#### **6.4 Сургалт явуулах газар ба багш нар:**

- Сургалтыг ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэг, чих хамар хоолой ба толгой хүзүүний мэс заслын мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалт явуулах эрх бүхий бааз, түшиц эмнэлгүүдийн чих хамар хоолойн тасгуудад түшиглэн явуулна.
- Сургалтыг үндсэн багшийн удирдлаган дор эмнэл-зүйн сургагч нар удирдан явуулах ба үндсэн багш нь зөвлөх зэрэг, эрдмийн зэрэг цолтой, багшлах эрх этгээд байна. Харин чиглүүлэгч эмнэл-зүйн багш бааз ба түшиц эмнэлгүүдэд резидентийн эмнэлзүйн тойролт хариуцах бөгөөд эмнэлзүйн сургагч багшийн эрхтэй байж болно.

#### **6.5 Сургалтын залгамж холбоо**

##### **1. Босоо тэнхлэгээр**

- Эрүүл бүтэц зүй
- Эмгэг бүтэц судлал
- Микробиологи

##### **2. Хэвтээ тэнхлэгээр**

- Мэс засал
- Дүрс оношлогоо
- Яаралтай тусламж-эрчимт эмчилгээ

#### **6.6 Сургалтын нөхцөл**

- Сургалт эрхлэгч байгууллага нь сургалтын хөтөлбөрийн дагуу онол, дадлагын сургалт явуулах орчин нөхцлийг бүрдүүлж ажиллах ба сургалтын түшиц эмнэлэг, чих хамар хоолойн мэргэжлийн онцлогт тохирсон сургалтын орчинг бүрдүүлж, суралцах хугацаандаа судалгаа, шинжилгээний ажил хийхийг урамшуулан дэмжинэ.
- Сургалтыг тойролт хэлбэрээр явуулах бөгөөд тойролтын хугацааг сургалтын сүлжээнд нэгдсэн эмнэлгүүдийн онцлог, хүчин чадалд нийцүүлэн сургалт эрхлэх үндсэн байгууллага төлөвлөн зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалтын албанаас гаргаж албаны дарга баталгаажуулна.
- Сургалт нь сүлжээнд нэгдсэн дээрх эмнэлгүүдийн амбулатори, хэвтэн эмчлүүлэх болон мэс заслын тасаг, хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг, сонголт, тэнцвэр судлалын лаборатори, сургалтын анги, танхимд явагдана

- Чих хамар хоолой судлалын тэнхим резидентийг сургалтын хөтөлбөр, мэргэжлийн багш, мэргэжлийн ном, сэтгүүл, сурах бичиг, интернэтэд ажиллах бололцоо нөхцлөөр хангана.
- “Чих хамар хоолой судлалын тэнхмийн резидент эмч нар үзлэг, мэс засал, сургалтанд оролцох заавар”-г бааз бүрт мөрдөж ажиллана. Хавсралт 2/

### 6.7 Хэрэглэгдэхүүн

- Ном, сурах бичгүүд
- Үзлэг ба мэс засал, ажилбарын багаж, төхөөрөмж
- Эм эмнэлгийн хэрэгсэл
- Субъект (Эмчлүүлэгч/шинжлүүлэгч)
- Эмчлүүлэгч/шинжлүүлэгчтэй холбоотой бичиг баримтууд
- Зөөврийн компьютер

### 6.8 Хувийн бэлтгэл

- Хувцас хэрэгсэл (халат, малгай, амны хаалт, шаахай, эмнэлгийн өмд цамц)-ийг бэлтгэсэн байна.
- Духны ба толгойн гэрэл бэлтгэсэн байна.
- Эмнэлгийн дотоод журмын дагуу цэвэр үзэмжтэй хувцаслана.
- Эмнэлгийн аюулгүй ажиллагааны журам, эмнэлзүйн халдвар хамгааллын дэглэмтэй танилцсан, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

### 6.9 Резидент хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн:

Мэдлэг	
1	Чих, хамар, залгиур, төвөнх ба толгой хүзүүний бүтэц, үйл ажиллагаа, чих хамар хоолойн эмгэгтэй хүнийг шинжлэх, оношлох, эмчлэх тухай ойлголт
2	Чих, хамар, залгиур төвөнхийн эмгэгүүдийн үед илрэх үндсэн хамшинжүүдийн үеийн эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн зарчим
Ур чадвар	
1	Хүний бие махбодийн бүтэц үйлийн онцлогт тохирсон үзлэгийг чих хамар хоолойн төрөл бүрийн багаж тоног төхөөрөмжийг ашиглан хийж, зонхилон тохиолдох ба зарим ховор эмгэгийн үед гардаг үндсэн хам шинжүүдийг илрүүлэн оношлох, тэдгээрт тохирсон эмчилгээний аргыг сонгон эмчлэх, зөвлөлгөө өгөх чадвар эзэмшинэ.
2	Чих хамар хоолойн яаралтай тусламжийг зөв, цаг алдалгүй үзүүлэх үзүүлэх чадвар эзэмшинэ.
3	Мэргэжлийн хүрээнд болон эмчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээнд харилцаж, ойлголцох, асуудлыг эерэгээр шийдвэрлэх чадварт суралцана.
4	Асуудлыг олон талаас нь эргэцүүлэн бодох, олон ургальч үзлээр авч үзэх, баг хамт олноороо хамтран ажиллах, асуудлын мөн чанарыг тодорхойлох чадварт суралцана.

Хандлага	
1	Үнэнч шударга, хариуцлагатай сурч, ажиллаж, эмчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалж, хүнлэг энэрэнгүй байх, хүнийг хайрлан хүндлэх, чин сэтгэлээсээ хандах эмчийн мэргэжлийн хандлагыг төлөвшүүлнэ.
2	Эмчлүүлэгчийн эрхийг хүндэтгэн хүнлэг энэрэнгүй хандаж, арьс өнгө, нас хүйс, нийгмийн байдал, шашин, эцэг эхийн эзлэх байр суурь, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхах байдалтай үл эвлэрэх ба тэдний зүгээс болон ар гэрээс үүсэх маргаан, үл ойлголцох асуудалд хүлээцтэй байр сууринаас хандана.
3	Тавилан муутай эмгэгийн оношийг тогтоогоод эмчлүүлэгчийн ар гэрт мэдэгдэх, тэдэнд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх зөв хандлагыг эзэмшинэ.
4	Өөрийгөө ба бусдыг хөгжүүлэх, сургах, багаар ажиллах, манлайлах хандлагад суралцана.
5	Үйлчлүүлэгчтэй болон эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцах ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

#### 6.10 Хөтөлбөрийг зохион байгуулах, хариуцах нэгж, хороо, захирал, харилцах хаяг

ЭМЯ-ны Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв, АШУҮИС-ийн Хөтөлбөрийн хороо, Сургалтын явуулах эрх бүхий байгууллагуудын Сургалтын бодлого зохицуулалтын газар (СБЗГ)-ын Мэргэжлийн сургалтын алба (МСА) нь нэгдсэн удирдлагаар хангана.

#### Чих хамар хоолой судлалын лекцийн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	Лекцийн сэдэв	Цаг
1	Хамрын эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага	27
2	Залгиурын эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага	
3	Төвөнхийн эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага	
4	Чихний эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага	
5	Сонсгол судлалын асуудлууд: BERA, Otoacoustic emission, ASSR шинжилгээнүүд, оношлогоо, ялган оношлогоо	
6	Сонсгол-тэнцвэрийн эмгэгүүд	
7	Хүзүү толгойн хавдрууд	
8	Хүүхдийн чих хамар хоолойн эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээ	
9	Чих хамар хоолойн яаралтай тусламж	
	<b>Нийт багц цаг</b>	<b>27</b>

**1-р лекцийн агуулгын тойм:** Хамрын бүтэц, үйл ажиллагаа, бичил түвшний бүтэц, хамрын зонхилон ба ховор тохиолдох эмгэгүүдийн талаар мэдлэг олгоно. Гадна хамрын ба хамрын хөндийн эмгэгүүд тэдгээрийн гаралтай нүдний болон гавал тархины хүндрэл, хүндрэлүүдийн үеийн мэс засал эмчилгээний ерөнхий зарчим, хамрын харшлын талаар орчин үеийн мэдээлэл өгч, нян судлал, радиологи, нэхдэсийн оношлогооны талаар орчин үеийн түвшинд мэдлэг олгоно.

**2-р лекцийн агуулгын тойм:** Залгиурын бүтэц, үйл ажиллагаа, бичил түвшний бүтэц, ховор тохиолдох эмгэгүүдийн талаар мэдлэг олгоно. Залгиурын гаралтай идээт үрэвслийн хүндрэлийн мэс заслын эмчилгээ, залгиурын дуран оношлогоо, улаан хоолойн зарим эмгэгүүдийн талаар онолын дэлгэрэнгүй мэдлэгтэй болгоно.

**3-р лекцийн агуулгын тойм:** Төвөнхийн бүтэц, үйл ажиллагаа, бичил түвшний бүтэц, төвөнхийн зонхилон ба ховор тохиолдох эмгэгүүдийн талаар мэдлэг олгоно. Төвөнхийн амьсгалах ба дуу гаргах үйл ажиллагааны хямрал, бачууралд хүргэдэг эмгэгүүдийн ялган оношлогоо, хүндрэлүүдийн үеийн арга хэмжээ, коникотоми, трахеостоми мэс засал, тэдгээрийн хүндрэл, трахеобронхоскопийн талаар мэдлэг олгоно.

**4-р лекцийн агуулгын тойм:** Чихний бүтэц, физиологийг микро түвшинд судлаж, чих сонсголын гажгууд, чихний гаралтай чамархайн ба гавал тархины хүндрэл, хүндрэлүүдийн үеийн мэс засал эмчилгээний зарчим, нэхдэс ба радиологийн шинжилгээний онцлог, чихний микроскоп судалгаа, дотор чихний сонсголын үйл ажиллагааны талаар онолын дэлгэрэнгүй мэдлэгийг олгоно.

**5-р лекцийн агуулга:** Аудиологи, акустикийн талаар онолын мэдлэг олгож, сонсголын шинжилгээнүүдийн заалт, үр дүн, шинжилгээний хариуд үнэлэлт дүгнэлт өгөх, орчин үеийн дэвшилтэт аргуудын талаар мэдлэг олгоно.

**6-р лекцийн агуулгын тойм:** Дотор чихний бүтэц үйл ажиллагааг микро түвшинд судлаж, дотор чихний тэнцвэрийн үйл ажиллагаа, тэнцвэрийн эмгэгүүд, толгой эргэлтийн оношлогоо, эмийн ба мэс заслын эмчилгээний талаар онолын мэдлэгтэй болно.

**7-р лекцийн агуулгын тойм:** Хүзүү толгойн зонхилон ба ховор тохиолдох хавдруудын бүтцийг микро түвшинтэй нь холбон судлаж, мэс засал ба хими, туяа эмчилгээ, хавдруудын үед хийгдэх оношлогооны аргуудын талаар онолын мэдлэг олгоно.

**8-р лекцийн агуулга:** Хүүхдийн чих хамар хоолойн зонхилон ба ховор тохиолдох эмгэгүүдийг хүүхдийн нас, бие бүтцийн динамик хөгжилтэй нь холбон судлаж, эмийн болон мэс заслын эмчилгээний талаар онолын мэдлэг олгоно.

**9-р лекцийн агуулга:** Чих хамар хоолойн эмгэгийн хүндрэлүүд, амь тэнссэн үеийн чих хамар ххоолойн яаралтай тусламжын мэдлэг олгоно.

### Мэргэшүүлэх хичээлийн тойролт

Эмнэлзүйн тойролтууд	Хугацаа	Тойролт хийх эмнэлгүүд
Үндсэн бааз эмнэлэг дээр чих хамар хоолойн суурь мэдлэг, чадвар, хандлага олгох сургалт	44 долоо хоног (нэгдүгээр дамжааны туршид)	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд
Эмнэл зүйн тойролт-1. Чих судлал	8 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд
Эмнэл зүйн тойролт-2. Хамар судлал	8 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд
Эмнэл зүйн тойролт-3. Төвөнх судлал	8 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэг
Эмнэл зүйн тойролт-4. Толгой хүзүүний мэс засал	4 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд
Эмнэл зүйн тойролт-5. Хүүхдийн чих хамар хоолой судлал	8 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэг
Эмнэл зүйн тойролт-6. Гоо сайхан-нөхөн сэргээх	2 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд
Эмнэл зүйн тойролт-7. Яаралтай тусламж-Эрчимт эмчилгээ	3 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд
Эмнэлзүйн тойролт-8. Сонсгол-тэнцвэр	3 долоо хоног	ЧХХ-н эмчийн мэргэжил олгох сургалтын эрх бүхий Анагаахын сургуулиуд, эмнэлэгүүд

Тайлбар: Мэргэшүүлэх хичээл 88 долоо хоногоо тойролтоор нь тавина.

### Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

№	Сургалтын хэлбэр	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
1	Амбулаторийн үзлэг, шинжилгээ	5	4 цаг. 7 хоногт 5 удаа	амбулатори	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
2	Хяналтын тойрох үзлэг	3-4	2 цаг. 7 хоногт 3 удаа	мэс заслын тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
3	Сургалтын тойрон үзлэг	2-4	1 цаг. 7 хоногт 1 удаа	мэс заслын тасаг, Сургалтын өрөө	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад суралцагч
4	Гардан хийх үйлдэл	3	2 цаг. 7 хоногт 3 удаа	ажилбарын өрөө эмчилгээний өрөө	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
5	Мэс засалд оролцох	3	2 цаг. 7 хоногт 1 удаа	мэс заслын тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
6	Сонсгол тэнцвэрийн шинжилгээ	2	2 цаг. 7 хоногт 2 удаа	сонсгол тэнцвэрийн лаборатори	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч

**Хяналтын тойрон үзлэг:** Суралцагч эмч хэвтэн эмчлүүлэхээр ирж байгаа өвчтөний биеийн байдлыг эмнэл зүйн сургагч багшид (бусад эмчид) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч бие даан эмчлүүлэгчтэй уулзаж асуумж цуглуулан, өвчний түүхтэй танилцаж, өвчтөний биеийн байдлыг үнэлж, урьдчилсан онош тавьж эмнэл зүйн сургагч багшид (бусад эмчид) танилцуулна.

Танилцуулгыг сургалтын өрөө гэх мэт өвчтөний өрөөнөөс өөр газар хийх бөгөөд хяналтын тойрон үзлэгээр өвчтнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

**Сургалтын тойрон үзлэг :** Сургалтанд тохиромжтой 1 өвчтөн сонгож мэргэжлийн үзлэг шинжилгээ хийж урьдчилсан онош тавьж, эмчилгээний төлөвлөгөө гарган

эмнэл зүйн сургагч багш болон хамтран суралцагч нарт танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэн байж болох хувилбаруудыг харилцан ярилцана.

### Танхимын сургалт (On-the-Job Training)

№	Аргачлал	Суралцагчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг дэхүүн	Хамтрагч
1	Бие даалт	1	Тохиромжтой цагт	Гэртээ, сургалтын танхим	Номын сан, интернет	Суралцагч, хамтран суралцагч
2	Лекц	10 хүртэл	7 хоногт 1 удаа 1-2 цаг	Сургалтын танхим	Танилцуулга (presentation)	Эмнэл зүйн сургагч багш
3	Журнал клуб	10 хүртэл	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, мэргэжлийн гадаад хэвлэлийн тойм	Суралцагч, Эмнэл зүйн сургагч багш
4	Симуляци, Дуураймал орчин	1-2 ээлжээр	2 цаг, 14 хоногт 1 удаа	Чамархай ясны лаборатори, сургалтын танхим	Чамархай яс	Эмнэл зүйн сургагч багш

#### Үйл ажиллагааны хуваарь:

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
08.00-12.00	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Мэс засалд оролцох	Амбулаторийн үзлэг
12.00-13.00	Хяналтын тойрон үзлэг		Хяналтын тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг	Хяналтын тойрон үзлэг
14.00-16.00	Гардан үйлдэл	Гардан үйлдэл	Сонсголын шинжилгээ	Тэнцвэрийн шинжилгээ	
16.00-17.00	Амбулаторийн үзлэг	Сургалтын тойрон үзлэг	Гардан үйлдэл	Чамархай ясны лабораторид	Лекц, Журнал клуб

#### Сэтгүүлийн хэлэлцүүлэг/ Journal review (1 сард 5-аас дээш өгүүлэл)

- Резидент нь удирдагч багштай хамтран сургалтын болон шинжлэх ухааны өгүүллийг сонгон авч уншиж бэлтгээд, хэлэлцүүлнэ.
- Резидент нь өөрийн сонгож авсан өгүүллийг багш ба бусад резидент эмч нарт 15 минутын хугацаанд танилцуулан тайлбарлаж, хэлэлцүүлнэ.
- Өгүүлэл нь сүүлийн 3 жилийн хугацаанд хэвлэгдсэн байхыг шаардана.

## **Номын хэлэлцүүлэг/ Book review (Сард 2 удаа)**

### **Нэгдүгээр дамжааны резидент эмч**

- Bailey's Head & Neck Surgery – Otolaryngology (2013, )
- Lange Current Diagnosis & Treatment, Otolaryngology, Head & Neck Surgery (2012, 3rd edition)
- Cummings otolaryngology, head & neck surgery, 5<sup>th</sup>-7<sup>th</sup> , 2016,2021

Резидент нь тухайн номны хуваарилж авсан бүлгийг уншиж хэлэлцүүлэгт бэлтгэж ирнэ. Резидент нь 20-30 минутын хугацаанд өөрийн хуваарилж авсан бүлгийг багш ба бусад резидент эмч нарт тайлбарлан танилцуулж, хэлэлцүүлнэ.

## **Тохиолдлын хэлэлцүүлэг/Case discussion (Grand Rounding) (Сард 1 удаа)**

- Резидент нь сургалтын эмнэлэгт өөрийн эмчилсэн, ажигласан, хагалгаа мэс ажилбарт нь оролцсон өвчтөний амбулатори болон тасагт байсан бүтэн түүхийг бэлтгэнэ.
- Чухал бөгөөд зонхилон тохиолддог өвчний түүхийг шаардана.
- Бүтэн түүхийг багтаана: Гол зовиур, өвчний түүх, бодит үзлэг, лабораторийн шинжилгээ, урьдчилсан оношийн таамаг, эмчилгээ, эмчилгээний үр дүн, тавиланг танилцуулахын зэрэгцээ тухайн өвчний талаархи онолын мэдээллийг хүргэнэ.
- Бэлтгэсэн түүхийг 15 минутийн хугацаанд бусад резидент эмч нарт танилцуулна.
- Профессорийн удирдлаганд тухайн тохиолдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ.

## **Дүрс оношлогооны зөвлөгөөн /Radiology conference (Хагас жил тутамд 2 удаа)**

- Хоёрдугаар дамжааны резидент эмч зөвлөгөөнд түүх бэлтгэнэ.
- Резидент бүр дүрс оношлогооны өвөрмөц зураг, CD-тэй 2 өвчтөний тохиолдлыг бэлтгэж ирнэ.
- 15 минутын хугацаанд бусад резидент эмч нарт танилцуулна.
- Профессорийн удирдлаганд тухайн дүрс оношлогооны арга, тохиолдлын талаар зөвлөлдөнө.

## **Аудиологийн зөвлөгөөн/Audiology conference (Хагас жил тутамд 2 удаа)**

- Хоёрдугаар дамжааны резидент эмч зөвлөгөөнд түүх бэлтгэнэ.
- Резидент бүр аудиологийн өвөрмөц шинжилгээ, CD-тэй 2 өвчтөний тохиолдлыг бэлтгэж ирнэ.
- 15 минутын хугацаанд бусад резидент эмч нарт танилцуулна.
- Профессорийн удирдлаганд тухайн сонсголын шинжилгээний талаар зөвлөлдөнө.

## **Бусад хэлэлцүүлэг**

- Чих хамар хоолой судлалын ба бусад тэнхмээс онцгой шаардлагатай гэж үзвэл бусад тэнхмийн багш нарыг лекц уншуулахаар урина. Үүнийг координатор багш зохицуулна.

- Хэрэв резидент эмч олон улсын хуралд оролцох шаардлага үүсвэл хөтөлбөрийн удирдагч ажиллах хуваарийг зохицуулна.

### **Долоо. Сургалтын агуулга**

#### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-1. ЧИХ СУДЛАЛ**

##### Зорилт:

Чихний зонхилон тохиолдох, гол эмгэгүүдийн оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

##### Заавал эзэмшвэл зохих мэдлэг

- Чихний бүтэц, үүсэл хөгжил, үйл ажиллагааг мэдэж, тайлбарлаж чаддаг болно.
- Чихний үзлэгийн багаж ба төхөөрөмжийг ашиглаж чаддаг болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчид чихний үзлэг хийж чаддаг болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчийн өвчний түүхийг цуглуулж чадвар эзэмшинэ.
- Чихний эмгэгтэй өвчтөний рентген зургийг уншиж сурна.
- Чихний дуранг хэрэглэж чаддаг болно.
- Чихний эмгэгийн үед өргөн хэрэглэгддэг эмийг ашиглаж чаддаг болно.
- Чихний мэс засалд хэрэглэгддэг багажуудыг мэддэг болно.
- Чихний эмгэгийн үед хэсэг газрын ба эмийн эмчилгээг хийж чаддаг болно.
- Эмчлүүлэгч, тэдний ар гэрт үзлэг, эмчилгээний талаар тайлбарлаж чаддаг болно.
- Амбулатори ба хэвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний бүх бичиг баримтыг хөтөлж сурна.
- Чихний эмгэгийн зонхилон тохиолдох хүндрэлийн оношлогоо, эмчилгээний талаар мэдлэгтэй болж, эмчлүүлэгч ба ар гэрт тайлбарлах чадвартай болно.
- Чихний мэс заслын талаар бусадад заах тайлбарлах чадвартай болно.
- Чихний эмгэгийн үеийн лабораторийн шинжилгээ, КТ, MRI шинжилгээний дүнг тайлбарлаж чаддаг болно.
- Чихний мэс заслын ахисан шатны ажилбарыг тайлбарлаж чаддаг болно.
- Чихний мэс заслын ач холбогдол ба чиг баримжааг тайлбарлах мэдлэгтэй болно.
- Сонсголын нарийвчилсан (PTA, Speech audiometry, OAE, ABR) шинжилгээний хариуг тайлбарлаж чаддаг болно.
- Тэнцвэрийн үйл ажиллагааны сорилуудыг гүйцэтгэж, дүгнэж, эмчлүүлэгчид тайлбарлах мэдлэгтэй болно.
- Чих шуугилт, толгой эргэлт, гэнэт сонсгол бууралтын талаар сайтар мэдлэгтэй болж эмчлүүлэгчид тайлбарлаж чаддаг болно.
- Чамархайн ясны өрөмдлөг (dissection)-ийн талаар мэдлэгийг эзэмшиж, тайлбарлах мэдлэгтэй болно.

- Сонсголын төхөөрөмжүүдийн төрөл, хэрхэн хэрэглэх талаар мэдлэгтэй, тайлбарлах чадвартай болно.
- Чамархай яс болон гавлын суурийн гэмтлийн талаар тайлбарлах чадвартай болно.

### **Заавал эзэмшвэл зохих чадвар**

- Гадна чихний хатгийг нээж, урсгуур тавих
- Өвчтөнд хэсэг газрын мэдээ алдуулалт хийх
- Гадна чихний сувгаас гадны биет авах чадварыг эзэмших
- Дэлбээний цус хуралтыг эмчлэх
- Сонсголын шинжилгээнүүдийг хийх чадвар эзэмших
- Илчит сорилыг хийх
- Чих шуугилт, толгой эргэлт, гэнэт сонсгол бууралтыг оношилж, эмчилж, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах чадвар эзэмших
- Хэнгэргэн хальсанд агааржуулах гуурс тавих
- Гадна чихний сувгаас эдийн шинжилгээ авах
- Тимпанопластик хагалгааны дараах хяналтыг хийх
- Чих орчмын төрөлхийн сүвийг эмчлэх
- Мирингопластик мэс заслыг багшийн хяналтанд хийж чадна.
- Энгийн мастойдэктоми мэс заслын үеийн зарим ажилбарыг багшийн хяналтанд хийж чаддаг болно.

### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-2 . ХАМАР СУДЛАЛ**

#### **Зорилт:**

Хамар, хамрын дайвар хөндийн эмгэгүүд, харшил, хамрын харшлын оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

#### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг**

- Хамар, дайвар хөндийн бүтэц, үүсэл хөгжил, үйл ажиллагааг мэдэж, тайлбарлаж чаддаг болно.
- Хамрын үзлэгийн багаж ба төхөөрөмжийг хэрэглэж чаддаг болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчид хамрын үзлэг хийж чаддаг болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчийн өвчний түүхийг цуглуулж чаддаг болно.
- Хамар дайврын рентген зураг КТ, MRI шинжилгээнүүдийг уншиж сурна.
- Хамрын дуранг хэрэглэж чаддаг болно.
- Хамрын эмгэгийн үед өргөн хэрэглэгддэг эмийг ашиглаж чаддаг болох ба хэсэг газрын эмийн бодисуудын талаар өргөн мэдлэгтэй болно.
- Хамрын мэс заслын багажуудыг мэддэг болно.
- Эмчлүүлэгч, тэдний ар гэрт хамрын үзлэг, эмчилгээний талаар тайлбарлах мэдлэгтэй болно.

- Амбулатори ба хэвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний бүх бичиг баримтыг хөтөлж сурна.
- Хамрын эмгэгийн зонхилон тохиолдох хүндрэлийн оношлогоо, эмчилгээний талаар мэдлэгтэй болж, эмчлүүлэгч ба ар гэрт хамрын гаралтай ухархайн ба гавал тархины хүндрэлийн талаар тайлбарлах чадвартай болно.
- Хамрын харшилт үрэвслийн эмгэг физиологийн үндсийг мэддэг болно.
- Харшлын ба харшлын бус хамрын үрэвслийн сорилуудын талаар мэдлэгтэй болж, сорилыг дүгнэж чаддаг болно
- Хамрын харшилд хэрэглэгдэх эмийн талаархи мэдлэгийг эзэмшинэ.
- Хамрын харшлын хэсэг газрын эмчилгээнд хэрэглэдэг цацлага, дусаалгын талаар мэдлэгтэй болно.
- Хамрын харшлын эмийн ба мэс заслын эмчилгээний талаар мэдлэгтэй болно.
- Хамрын харшлын талаар өвчтөнд мэдээлэл, зөвлөгөө өгөх мэдлэгтэй болно.
- Тасгийн өвчтөний үзлэг болон эмчилгээний талаар тайлбарлаж чаддаг болно.
- Хамрын мэс заслын талаар бусдад заах тайлбарлах мэдлэгтэй болно.
- Ринопластик мэс засал хийх өвчтөний зурган дээр гоо зүйн чухал цэгүүдийг тайлбарлах мэдлэгтэй болно.
- Хамрын мэс заслын ахисан шатны ажилбарын талаар мэдлэгтэй болно.
- Олон улсын риносинуситийн эмнэлзүйн удирдамжийг мэддэг, бусдад тайлбарлаж чаддаг болно.
- Хамрын мэс заслын ач холбогдол ба чиг хандлагыг тайлбарлаж чадна.

#### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг чадвар**

- Амбулаторийн өвчтөнд ерөнхий ба хамар дайврын үзлэг хийх чадвартай болно.
- Хамрын харшлыг оношлох, эмчлэх чадвартай болно
- Харшлын ба харшлын бус хамрын үрэвслийг ялган оношлоод эмчилгээг төлөвлөх чадвартай болно.
- Хамрын харшлын талаар өвчтөнд мэдээлэл, зөвлөгөө өгч чадна.
- Амбулаторт хэрэглэгдэх багаж төхөөрөмжийг үзлэгт бэлтгэж чадна.
- Өвчтөний үзлэгийн тэмдэглэлийг бичиж чадна.
- Өвчтөний оношлогооны болон эмчилгээний төлөвлөгөөг гаргаж чадна.
- Хамрын эмгэгийн үед хэсэг газрын ба эмийн эмчилгээг хийж чаддаг болно.
- Мэс заслын өрөөнд 10-с доошгүй хагалгааг бэлдэх чадвартай болно.
- Хамарт хэсэг газрын мэдээ алдуулалт хийх чадвартай болно.
- Хамрын дурангаар үзлэг оношлогоо хийж чаддаг болно.
- Хамраас гадны биет авч чадна.
- Хагалгааны дараах өвчтөнүүдийн хамрын хөндийн цэвэрлэгээг хийж чаддаг болно.
- Септопластик болон доод самалдаг тайрах( inf.turbinoplasty) хагалгааны дараах хяналтыг хийж чаддаг болно.
- Хамрын цус алдалтыг тогтоож чаддаг болно.

- Хамрын ясны хугаралын мембранжийг эзэмшинэ.
- Canine fossa antrostomy & зажуур хөндийг дунд жимээр угааж чаддаг болно.
- Хамрын хөндий дахь полипэктоми хагалгааг хийж чаддаг болно.
- Септопластик доод турбинопластик хагалгаа хийж чаддаг болно.
- Anterior ESS (uncinectomy, antrostomy, ба anterior ethmoidectomy) мэс заслуудыг багшийн хяналтанд хийж чаддаг болно.

### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-3. ТӨВӨНХ СУДЛАЛ**

#### Зорилт:

Багалзуур, төвөнхийн талаар ерөнхий ойлголт, төвөнхийн зонхилон тохиолдох эмгэгүүдийн оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

#### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг**

- Төвөнхийн бүтэц, үүсэл хөгжил, үйл ажиллагааг мэдэж, тайлбарлаж чаддаг болно.
- Төвөнхийн үзлэгийн багаж ба төхөөрөмжийн талаар мэдлэгтэй болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчид төвөнхийн үзлэг хийх мэдлэгтэй болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчийн өвчний түүхийг цуглуулж чаддаг болно.
- Төвөнхийн эмгэгтэй өвчтөний рентген зураг, КТ, MRI шинжилгээнүүдийг уншиж сурна.
- Төвөнхийн дурангийн талаар мэдлэгтэй болно.
- Төвөнхийн шинжилгээнүүдийн талаар мэдлэгтэй болж, түүнийг хийж сурна.
- Төвөнхийн эмгэгийн үед өргөн хэрэглэгддэг эмийн талаар мэдлэгтэй болж, хэсэг газрын ба эмийн эмчилгээг хийж чаддаг болно.
- Бачуурлын үед яаралтай ба хойшлуулашгүй арга хэмжээ авч чадах мэдлэгийг эзэмшинэ.
- Дууны эмгэгүүдийг оношлох, ялган оношлох мэдэлэгтэй болно.
- Төвөнхийн мэс засалд хэрэглэгддэг багажуудыг мэддэг болно.
- Эмчлүүлэгч, тэдний ар гэрт үзлэг, эмчилгээний талаар тайлбарлаж чаддаг болно.
- Амбулатори ба хэвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний бүх бичиг баримтыг хөтөлж сурна.
- Төвөнхийн эмгэгийн зонхилон тохиолдох хүндрэлийн оношлогоо, эмчилгээний талаар мэдлэгтэй болж, эмчлүүлэгч ба ар гэрт тайлбарлах чадвартай болно.
- Төвөнхийн мэс заслын талаар бусад заах тайлбарлах мэдлэгтэй болно.
- Төвөнхийн мэс заслын ахисан шатны ажилбарыг тайлбарлаж чаддаг болно.
- Төвөнхийн мэс заслын ач холбогдол ба чиг баримжааг тайлбарлах мэдлэгтэй болно.

### **Заавал эзэмшвэл зохих чадвар**

- Төвөнхийн шууд дурандалт хийж чаддаг болно.
- Өвчтөний амьсгалын замыг дүгнэх чадварыг эзэмшинэ.
- Төвөнхийн салстын хоргүй өвчнийг оношлох, эмчлэх чадвартай болно.
- Трахеостоми тавих чадвартай болно.
- Төвөнхийн бичил мэс заслыг багшийн хяналтанд хийх чадвартай байх

### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-4 ТОЛГОЙ -ХҮЗҮҮНИЙ МЭС ЗАСАЛ**

#### **Зорилт:**

Толгой хүзүү, түүнд тохиолдох эмгэгүүдийн талаар ерөнхий ойлголт, зонхилон тохиолдох хортой ба хоргүй хавдруудын оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

#### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг**

- Толгой хүзүү ба залгиурын бүтэц, үүсэл хөгжил, үйл ажиллагааг мэдэж, тайлбарлаж чаддаг болно.
- Толгой хүзүү ба залгиурын үзлэгийн багаж ба төхөөрөмжийн талаар мэдлэгтэй болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчид толгой хүзүү ба залгиурын үзлэг хийх мэдлэгтэй болно.
- Амбулаториор үйлчлүүлэгчийн өвчний түүхийг цуглуулж чаддаг болно.
- Толгой хүзүү ба залгиурын эмгэгтэй өвчтөний рентген зураг, КТ, MRI шинжилгээнүүдийг уншиж сурна.
- Хамар залгиурын уян дурангийн дурангийн талаар мэдлэгтэй болж, түүнийг ашиглаж сурна.
- Толгой хүзүү ба залгиурын өвчний үед өргөн хэрэглэгддэг эмийн талаар мэдлэгтэй болж, хэсэг газрын ба эмийн эмчилгээг хийж чаддаг болно.
- Толгой хүзүү ба залгиурын мэс засалд хэрэглэгддэг багажуудыг мэддэг болно.
- Эмчлүүлэгч, тэдний ар гэрт үзлэг, эмчилгээний талаар тайлбарлаж чаддаг болно.
- Амбулатори ба хэвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний бүх бичиг баримтыг хөтөлж сурна.
- Амбулаторийн үзлэг болон эмчилгээний талаар бусдад тайлбарлах мэдлэгийг эзэмшинэ.
- Толгой хүзүү ба залгиурын эмгэгийн зонхилон тохиолдох хүндрэлийн оношлогоо болон эмчилгээний талаар мэдлэгийг эзэмшинэ.
- Толгой хүзүү ба залгиурын мэс заслын талаар зохих түвшний мэдлэгийг эзэмшиж, бусдад заах тайлбарлах чадвартай болно.
- Толгой хүзүү ба залгиурын эмгэгийн лабораторийн шинжилгээ, КТ, MRI шинжилгээнүүдийн дүнг тайлбарлаж чаддаг байх
- Толгой хүзүү ба залгиурын мэс заслын ахисан шатны ажилбарыг мэддэг, тайлбарлах чадвартай болно.

- Нүүрний саажилтын үеийн сорилуудыг мэддэг, хийх ажилбарыг тайлбарлаж чаддаг болно.
- Толгой хүзүүний хавдрын үе шатыг ангилах мэдлэгтэй болно.
- Толгой хүзүүний өвчнүүдийн үеийн гистологийн шинжилгээний дүнг уншиж ойлгох мэдлэгтэй болно.
- Толгой хүзүүний хагалгааны үеийн унтуулгын онцлогийг мэднэ.
- Бамбай булчирхайн хортой хоргүй өвчнүүд, болон хүзүүнд тохиолдох хавдар, хавдар төст эмгэгүүдийн талаар зохих түвшний мэдлэгтэй болно байх .
- АТЕ мэс заслын олон улсын эмнэлзүйн удирдамжийг мэддэг, түүний өвчтөний эцэг эхэд тайлбарлах мэдлэгтэй болно.
- Хамар болон толгой хүзүүний мэс заслын ач холбогдол ба чиг хандлагыг мэддэг, түүнийг тайлбарлаж чаддаг болно.

#### **Заавал эзэмшвэл зохих чадвар**

- Мэс заслын төрөл бүрийн хэлбэрийн оёдлуудыг тавьж чаддаг болно.
- Мэс заслын зангилаа хийх чадвартай болно.
- Амны хөндийн хавдар, хавдар төст үүсгэвэрээс эдийн шинжилгээ авах чадвартай болно.
- Гүйлс орчмын буглаанд зүслэг болон урсгуур тавих
- Арьсан доорх эдийн гэмтэлд оёдол тавьж сурах
- Z-plasty, W-plasty зэрэг оёдолуудыг тавьж сурах
- Аденойдэктоми болон тонзиллэктоми хагалгаа, хагалгааны дараах хяналт хийх
- Френотоми хагалгааг хийх
- Хүзүүний тунгалагийн булчирхайнаас эдийн шинжилгээ авч сурах
- Шүлсний булчирхайн чулууг авах
- Хяналтан доор эрүүн доорх булчирхайд мэс ажилбар хийх чадвартай болох

### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-5. ХҮҮХДИЙН ЧИХ ХАМАР ХООЛОЙ СУДЛАЛ**

#### **Зорилт:**

Хүүхдэд зонхилон тохиолдох чих хамар хоолой ба толгой хүзүүний эмгэгүүдийн талаар ерөнхий ойлголт, оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

#### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг**

- Хүүхдийн чих хамар хоолой ба толгой хүзүүний бүтэц, үүсэл хөгжил, үйл ажиллагааг мэдэж, тайлбарлаж чаддаг болно
- Хүүхдийн сонсгол тэнцвэрийн эрхтэний талаар мэдлэг эзэмших
- Хүүхдийн сонсголын шинжилгээнүүдийн талаар мэдлэгтэй болох
- Хүүхдийн хамар, хамрын дайвар хөндийн эмгэгүүдийн талаар мэдлэгтэй болох
- Хүүхдийн залгиур, төвөнх, толгой хүзүүний эмгэгүүдийн талаар мэдлэгтэй болох
- Хүүхдэд амбулаториор үзлэг хийх чадвар эзэмших
- Хүүхдийн эцэг эхээс өвчний түүхийг цуглуулах

- Хүүхдийн чих хамар хоолойн эмгэгүүдийн үед өргөн хэрэглэгддэг эмийн талаар мэдлэгтэй болж, хүүхдийн жин ба насанд тохируулах чадвар эзэмших
- Хүүхдэд хэсэг газрын ба эмийн эмчилгээг хийж чаддаг болох
- Хүүхдийн эцэг эхэд үзлэг, эмчилгээний талаар тайлбарлах мэдлэгийг эзэмших.
- Амбулатори ба хэвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний бүх бичиг баримтыг хөтөлж сурах
- Хүүхдийн чих, хамар-дайвар, залгиурын эмгэгийн зонхилон тохиолдох хүндрэлийн оношлогоо болон эмчилгээний талаар мэдлэгийг эзэмших
- Хүүхдийн дунд чихний мэс засал, залгиурын мэс заслын талаар зохих түвшний мэдлэгийг эзэмшиж, бусдад заах тайлбарлах чадвартай болох
- Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгүүдийн лабораторийн шинжилгээ, КТ, MRI шинжилгээнүүдийн дүнг тайлбарлаж чаддаг байх
- Хүүхдийн чих, хамар-дайвар, залгиурын мэс заслын ахисан шатны ажилбарыг мэддэг, тайлбарлах чадвартай болн
- Хүүхдийн дүлийрэлт, сонсгол бууралтын талаар мэдлэгтэй болно.
- Хүүхдийн хагалгааны үеийн хэсэг газрын мэдээгүйжүүлэг ба унтуулгын онцлогийг мэднэ.

#### **Заавал эзэмшвэл зохих чадвар:**

- Хүүхдийн бие махбодийн бүтэц үйлийн онцлогт тохируулан чих хамар хоолой, толгой хүзүүний эмнэлзүйн үзлэгийг хийх чадвартай болох
- Хүүхдэд чих хамар хоолойн яаралтай тусламжийг зөв, цаг алдалгүй үзүүлэх чадвар эзэмших
- Чих хамар хоолойн багажийн болон эмнэлзүйн шинжилгээ, сорилуудыг хийж сурах
- Чих хамар хоолойн эмчилгээний эм бэлдмэлийг хяналттай, зохистой, зөв хэрэглэх чадвар эзэмших
- Хүүхэд, тэдний ар гэрт зөвлөлгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох чадвартай болох

### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-6 ГОО САЙХНЫ МЭС ЗАСАЛ**

#### **Зорилт:**

Хамар, нүүрний бүтэц, үйл ажиллагаа, гоо сайхныг алдагдуулж буй төрөлхийн болон олдмол согог, өвчин эмгэгийг эмчлэх, үйл ажиллагаа ба гоо сайхныг сэргээх талаар ерөнхий ойлголт, оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

#### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг**

- Хамар, нүүрийг хамарсан төрөлхийн ба олдмол гажууд, эмгэгүүд, түлэгдэл, сорви, гэмтлүүд, тэдгээрийн шалтгаан, эмгэг жам, оношилгоо, ялган оношилгоо, хүндрэлийн талаар зохих түвшний мэдлэгтэй болно.
- Нөхөн сэргээх, гоо сайхны мэс заслын үндсэн суурь зарчим, хамар ба нүүрний нөхөн сэргээх, гоо сайхны мэс заслын зарчмууд, гавал, нүүр, толгой хүзүүний нөхөн

сэргээх мэс засал, хүүхдийн нөхөн сэргээх мэс заслын талаар зохих түвшний мэдлэгийг эзэмшинэ.

#### **Заавал эзэмшвэл зохих чадвар**

- Нүүрний нөхөн сэргээх, гоо сайхны мэс заслын хэрэгцээ шаардлагатай хүнд оношилгоо хийх чадвартай болно.
- Нүүрний нөхөн сэргээх, гоо сайхны мэс заслын хэрэгцээ шаардлагатай хүнд шинжилгээний төлөвлөгөө зохиох, шинжилгээний хариуг уншиж, дүгнэлт хийх чадвартай эзэмшинэ
- Эмчлүүлэгчид шаардлагатай мэс заслыг төлөвлөгөөт ба яаралтай журмаар хийх заалтыг сонгох, мэс заслыг гүйцэтгэх, мэс заслын үеийн ба дараахь болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хүндрэлийг эмчлэх, мэс заслын дараах эмчилгээ, асаргаа сувилгааг зөвлөж, хяналт тавих чадвар эзэмшинэ.
- Нөхөн сэргээх, гоо сайхны мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлж, шаардлагатай бичиг баримт хөтлөх, бусад нарийн мэргэжлийн эмч нартай хамтран ажиллах чадвартай болно.
- Ринопластик мэс заслыг багшийн хяналтанд хийж чаддаг болно
- Блефаропластик мэс заслын зарим ажилбарыг багшийн хяналтанд хийж чаддаг болно.

#### **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-7 Яаралтай тусламж-эрчимт эмчилгээ**

##### **Зорилт:**

Амь тэнссэн үеийн яаралтай тусламж, чих хамар хоолой, хүзүү толгой эмгэгүүдийн хүндрэлүүдийн үеийн яаралтай тусламж, мэс заслын дараахь эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээний анхан шатны мэдлэг, хандлагыг эзэмшинэ.

##### **Заавал эзэмшвэл зохих мэдлэг**

- Амь тэнссэн үеийн яаралтай тусламжын үндэс
- чих хамар хоолой, хүзүү толгой эмгэгүүдийн хүндрэлүүдийн үеийн яаралтай тусламжын үндэс
- Мэс заслын дараах эрчимт эмчилгээний тусламжын үндэс

##### **Заавал эзэмшвэл зохих хандлага**

- Үнэнч шударга, хариуцлагатай сурч, ажиллаж, эмчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалж, хүнлэг энэрэнгүй байх, хүнийг хайрлан хүндлэх, чин сэтгэлээсээ хандах эмчийн мэргэжлийн хандлагыг төлөвшүүлнэ.
- Эмчлүүлэгчийн эрхийг хүндэтгэн эелдэг боловсон, хүнлэг энэрэнгүй, ялгаварлалгүй хандаж, үзлэг, шинжилгээ, эмчилгээ, боолтыг хийхдээ өвтгөхгүй байх энэрэнгүй хандлага, өөртөө итгэлтэй эмчлүүлэгчид итгэл төрүүлэхээр ажиллах хандлагыг төлөвшүүлнэ.
- Эмчлүүлэгч болон ар гэрээс үүсэх маргаан, үл ойлголцох асуудалд хүлээцтэй байр сууринаас хандана.

- Хагалгааны хэсэгт ажиллаж байгаа эмч, сувилагч нар, хамтран суралцаж байгаа резидентүүд, эмнэлэгийн ажилтнууд, туслах ажилчидтай харилцах ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.
- Өөрийгөө ба бусдыг хөгжүүлэх, сургах, багаар ажиллах, манлайлах хандлагад суралцана.

## **ЭМНЭЛ ЗҮЙН ТОЙРОЛТ-8. СОНСГОЛ-ТЭНЦВЭР СУДЛАЛ**

### **Сонсгол судлал**

#### **Зорилт:**

Чих-сонсголын зонхилон тохиолдох, гол эмгэгүүдийн оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

#### **Эзэмших мэдлэг**

- Чих шуугилт, толгой эргэлт, гэнэт сонсгол бууралтын талаар сайтар мэдлэгтэй болж эмчлүүлэгчид тайлбарлаж чаддаг болно
- Сонсголын төхөөрөмжүүдийн төрөл, хэрхэн хэрэглэх талаар мэдлэгтэй, тайлбарлах чадвартай эзэмшинэ
- Сонсголын бууралтанд хүргэдэг төрөлхийн эмгэгүүд, оношлогоо, эмчилгээний талаар тайлбарлаж сурах
- Сонсголын бууруулах олдмол эмгэгүүд, оношлогоо-эмчилгээний талаар тайлбарлаж сурна
- Дамжуулах замын гаралтай сонсгол бууралтын оношлогоо-эмчилгээний талаар тайлбарлах чадвартай болно
- Мэдрэл-мэдрэхүйн гаралтай сонсгол бууралтын оношлогоо-эмчилгээний талаар тайлбарлах чадвартай болно
- Мэргэжлийн шалгаант сонсголын бууралт, хөдөлмөр магадлал, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох талаар тайлбарлах чадвартай болно
- Акустикийн үндэс талаар тайлбарлах чадвартай болно
- Дунгийн суулгац, ВАНА аппаратны талаар мэдлэг олгох талаар тайлбарлах чадвартай болно
- Сонсголын аппарат, дунгийн суулгац, ВАНА тохируулгын дараах нөхөн сэргээлт, хэл засал судлалын талаар тайлбарлах чадвартай болно

#### **Чадвар**

- Сонсголын анализаторыг шинжлэх субъектив болон объектив шинжилгээний аргуудыг эзэмшинэ
- ASSR (Auditory Steady state Responce) шинжилгээний аргыг эзэмшинэ
- ABR (Auditory Brainstem Responce) шинжилгээний аргыг эзэмшинэ
- OAE (Oto Acoustic Emission) шинжилгээний аргыг эзэмшинэ
- Tympanometry шинжилгээний аргыг эзэмшинэ
- Үгийн аудиометр шинжилгээний аргыг эзэмшинэ

- Цэвэр авианы аудиометр (тоглоомын аудиометр, харж батжуулах аудиометр) шинжилгээний аргыг эзэмшинэ
- Чих шуугилт, толгой эргэлт, гэнэт сонсгол бууралтыг оношилж, эмчилж, эмчилгээний төлөвлөгөөг шийдвэрлэж чаддаг болно
- Хэнгэргэн хальсанд агааржуулах гуурс тавьж чадна
- Тимпанопластик хагалгааны дараах хяналтыг хийж чадна

### Тэнцвэр судлал

#### Зорилт:

Чих-тэнцвэрийн зонхилон тохиолдох, гол эмгэгүүдийн оношлогоо эмчилгээний үндсэн мэдлэг, чадварыг олгож хандлагыг эзэмшүүлнэ.

### Эзэмших мэдлэг

- Чих шуугилт, толгой эргэлт, гэнэт сонсгол бууралтын талаар сайтар мэдлэгтэй болж эмчлүүлэгчид тайлбарлаж чаддаг болно
- Тэнцвэр шалгах төхөөрөмжүүдийн төрөл, хэрхэн хэрэглэх талаар мэдлэгтэй, тайлбарлах чадвартай болно
- Тэнцвэр алдагдалд хүргэдэг төрөлхийн эмгэгүүд, оношлогоо, эмчилгээний талаар тайлбарлах чадвартай болно
- Тэнцвэр алдагдалд хүргэдэг олдмол эмгэгүүд, оношлогоо-эмчилгээний талаар тайлбарлах чадвартай болно

### Ашиглах ном, сурах бичгүүд:

- Bailey's Head & Neck Surgery – Otolaryngology (Johnson & Rosen, 2013),
- Ballenger's otorhinolaryngology head and neck surgery (2003)
- Lange Current Diagnosis & Treatment, Otolaryngology, Head & Neck Surgery (3<sup>rd</sup> edition, 2012, ),
- Cummings Otolaryngology, H&N surgery (Paul w. Flint etc. 2010, 2015, 2020),

### **Найм. Сургалтын үнэлгээ**

- 8.1** Сургалт эрхлэх байгууллага нь ажлын байрны сургалтыг удирдан явуулах эмнэл зүйн сургагч багш нарыг томилон хуваарилна. Сургалтын явц, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, хяналт тавих сургалт хариуцагч (mentor) –ыг сургалт эрхлэх байгууллага томилон ажиллуулна. Сургалт хариуцагч нь сар бүр 1 удаа тогтмол уулзалт зохион байгуулж суралцагч эмч нартай мэдээлэл солилцож үнэлгээтэй танилцана.
- 8.2** Тойролт бүрт суралцагч эмчийг сүлжээнд нэгдсэн эмнэлгүүдэд илгээж тойролтын хугацаанд хэрэгжүүлэх зорилтыг танилцуулна. Тойролт дуусахад тойролт удирдсан багштай ярилцлага хийж сургалтын үнэлгээ, зөвлөгөө авна.
- 8.3** Үнэлгээний арга нь сургалтын явцын үнэлгээ, төгсөлтийн шалгалт гэсэн хоёр хэлбэрээр хийгдэнэ.
  - Төгсөлтийн шалгалт- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулах “Чих хамар хоолой судлал” сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтанд

тэнцсэн тохиолдолд Чих хамар хоолой судлалын үндсэн мэргэшлийн үнэмлэх олгоно.

- Ажлын байранд суурилсан үнэлгээ:

**360 хэмийн үнэлгээ** Суралцагч эмчийн мэргэжлийн байх (professional), манлайлагч (leader) байх чадамжийг үнэлэхэд хэрэглэнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. Хяналтын дэвтрээс ирцийн үнэлгээг сургалтын алба гаргаж нэгтгэнэ.

**Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini – clinical evaluation exercise. Mini -CEX)**

Ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал таньж мэдэх 25 шинж тэмдгүүдээс 5-аас доошгүй үйлдэл бүрд 3-аас доошгүй удаа нийт 15-аас цөөнгүй удаа үнэлгээ хийнэ.

**Ур чадварыг шууд ажиглан дүгнэх үнэлгээ (Direct observation of prosedural skills. DOPS)** Сургалтын эхний жилд ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал хийж гүйцэтгэх 20 үйлдлээс 15- аас доошгүй үйлдлийг хийж чаддаг болсныг эмнэл зүйн удирдагч багш нотолсон үнэлгээ. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

**Портфолио үнэлгээ (Portfolio Assessment)** Суралцагч эмч нь сургалтын хугацаанд оролцсон сургалт, эрүүл мэндийн сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бичиг баримтыг цуглуулж өөрийн сургалтын хавтсанд хадгална.

#### 8.4 Үнэлгээний дүнг хянах

Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд эмнэл зүйн сургагч багшийн өгсөн үнэлгээг сургалтын албанд хүлээлгэн өгч тэмдэглүүлнэ.

Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд нэгтгэн танилцуулж байна.

#### 8.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini –CEX, DOPS, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт заагдсан зайлшгүй шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

Зайлшгүй сургалтанд оролцсон байх өдрийн тоо буюу ирц, сургалтын ирц хангалтгүй бол тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 20 шинж тэмдгээс 1 жилийн хугацаанд 20-иос доошгүйг оношилж, эмчилж туршлага хуримтлуулсан байна.

“Чих хамар хоолой судлал” үндсэн мэргэшлийн сургалтын тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 50-иас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.

Сонсгол судлалын тойролтоор заагдсан шинжилгээний аргаас тус бүр 10-аас доошгүй удаа гүйцэтгэж, дүгнэлт хийж туршлага хуримтлуулсан байна.

Тэнцвэр судлал судлалын тойролтоор заагдсан шинжилгээний аргаас тус бүр 5-аас доошгүй удаа гүйцэтгэж, дүгнэлт хийж туршлага хуримтлуулсан байна.

Хүүхдийн чих хамар хоолой, сонсгол судлалын тойролтоор заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 20-иас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна. Чих хамар хоолойн хавдар судлал судлалын тойролтоор заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 20-иас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй суралцах 20 гардан үйлдлээс нэг жилийн хугацаанд 80%-аас цөөнгүйг хийж гүйцэтгэн туршлага хуримтлуулсан байна.

## **Ес. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, хяналт**

### **9.1 Сургалтын хяналтын зөвлөл**

1. Сургалт эрхлэгч байгууллагын сургалтын албаны дарга, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд дарга, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Чих, хамар, хоолойн мэс заслын тасаг, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын тасгийн хариуцагч (mentor), сувилахуйн албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ.
2. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн даргын шууд удирдлага доор ажиллана.
3. Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
4. Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
5. Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

### **9.2 Хөтөлбөрийн хяналт**

1. Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
3. Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж, хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

### **9.3 Сургалтын танилцуулга (Orientation)**

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдаа тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаа эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

**Чих хамар хоолойн резидентүүдийн түшиц эмнэлгүүдийн  
чих хамар хоолойн тасагт ажиллах журам**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Чих хамар хоолойн мэргэжлээр суралцаж байгаа резидент эмч нь эмнэлзүйн түшиц эмнэлгүүдийн чих хамар хоолойн тасагт ажиллахдаа энэхүү журмыг баримтална.
- 1.2. Резидент эмч нь эмнэлзүйн сургалтаар чих хамар хоолойн шинжлэх ухааны орчин үеийн мэдлэгийг эзэмшиж, чих хамар хоолойн эмгэгтэй эмчлүүлэгчийг үзэх, шинжлэх, үнэлэх, эрэмблэх, оношлох, эмчлэх, зөвлөх ур чадварыг эзэмшсэний үндсэн дээр хөтөлбөрийн хүрээний гардан үйлдэл ба зарим мэс заслуудыг хийх чадварыг эзэмшинэ.
- 1.3. Суралцах хугацаандаа тухайн тасгуудын хууль, дүрэм, дотоод журам, ёсзүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.

Хоёр. Резидент эмчийн эрх үүрэг

- 2.1. Энэхүү санамжид заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 2.2. Резидентийн тойрох сургалтын дагуу, урьдчилан төлөвлөсөн хугацаагаар түшиц эмнэлгийг орхин явна.
- 2.3. Хариуцсан багш, тэнхим/тасгийн эрхлэгчийн албан ёсны зөвшөөрлөөр чих хамар хоолойн чиглэлээр зохиогдож буй гадаад дотоодын сургалт, семинарт богино хугацаагаар (7-14 хоног) оролцох эрхтэй.
- 2.4. Тасагт байгаа номын санг зохих карт бүртгэлийг баталгаажуулан зөвшөөрөлтэйгээр ашиглах эрхтэй.
- 2.5. Багшийн удирдлага дор судалгааны ажил хийх, материал цуглуулах эрхтэй.
- 2.6. Тасгийн өглөөний яриа, эмнэлзүйн болон эмгэг судлалын хурал, мэргэжлийн сургалтанд оролцох эрхтэй.
- 2.7. Эмчлүүлэгчийг үзэх, шинжлэх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн хүрээнд ажилбар, мэс засал хийх зэрэг үйл ажиллагааг хариуцсан эмч/багшийн хяналтанд хийх эрхтэй.
- 2.8. Түшиц байгууллагын захиргаанаас зохион байгуулсан олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, цаг үеийн ба нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцох эрхтэй/үүрэгтэй.
- 2.9. Резидент эмч нь багшид туслах үүрэгтэй.
- 2.10. Хоёрдугаар дамжааны резидент нь тухайн тасгийн үйл ажиллагаа, дотоод журамтай танилцах, дадахад нэгдүгээр дамжааны резидентэд туслах үүрэгтэй.
- 2.11. Байгууллага, хувь хүн, ажил үүрэг, ялангуяа үйлчлүүлэгчтэй холбоотой нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.
- 2.12. Резидент нь өөрийн хийсэн ажил, сурсан зүйлийг өдөр тутамд тэмдэглэн, долоо хоног тутамд багшаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.

Гурав. Ажил, амралтын цаг

- 3.1. Долоо хоногт доод тал нь 40 цаг (өдөр бүр 8 цаг), дээд тал нь 52 цаг (1 удаагийн дежур-12 цаг) эмнэлэгт ажиллана.
- 3.2. Тухайн бааз эмнэлэгийн өглөөний ажил эхлэхээс тарах цагийг хүртэлх бүх хугацаанд ажиллана.
- 3.3. Үдийн цайны цагт чөлөөтэй байна.
- 3.4. Долоо хоногт нэг удаа дежур хийнэ.
- 3.5. Дежуртэй хоносон тохиолдолд дараа өдрийн 12 цагт ажлаа дуусгаж, хариуцсан эмч/багшийн зөвшөөрлөөр явж болно.
- 3.6. Цагийн бүртгэл нь тухайн резидентийн кредит цагийг тооцох баримт болно.
- 3.7. Хувийн шалтгаанаар бүтэн өдрөөс дээш хугацааны чөлөө авах бол тэнхмийн координатор багшид бичгээр өргөдөл гаргана.
- 3.8. Нийтээр амрах баярын өдрүүдэд амарна. Баярын өмнөх ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.
- 3.9. Жилд 28 хоног амарна (өвөл-14 хоног, зуны амралт-14 хоног)

**Чих хамар хоолойн резидент эмч нар  
үзлэг, мэс засал, сургалтанд оролцох заавар**

Үзлэг хариуцсан резидент эмч:

8:30 ~ 17:00

- Үзлэгийн өрөөнд 2 резидент ажиллана.
- Өглөө ирмэгц үзлэгийн өрөөний кварц асааж, өрөөг агааржуулна
- Өмнөх өдөр үзлэг хариуцсан резидент эмч дараа өдрийн үзлэгийн бэлтгэлийг хангаж, өрөөг цэвэрлүүлж явна.
- Багш нарын үзлэгт туслах, өвчтөний үзлэгийг бичих, зөвлөгөө өгөхөд тусална.
- Мэс засалд орсон өвчтөний хяналтын үзлэг хийх ба зөвлөгөөг өгнө.
- Мэс засалд орох өвчтөнийг унтуулгын эмчид үзүүлнэ.
- Өглөө ирээд үзлэгийн багаж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, ариутгалаас ариутгасан багаж авах ба үзлэгт бэлэн байлгана.
- Эмнэлэгийн цахим системийн программыг үзлэгт бэлтгэх, ажиллахад бэрхшээл үүссэн тохиолдолд яаралтай программистыг дуудаж засуулна.
- 7 хоног бүрийн Пүрэв гаригт мэс заслын төлөвлөгөөг гаргаж мэс заслын өмнөх болон ариутгалын хэсэгт өгнө.
- Өдрийн ажил
  - 08:30-10:00-д мэс засалд орсон эмчлүүлэгчидтэй ажиллана.
  - 10:00 цагаас 1 резидент багшийн үзлэгт тусалж, 1 нь эмнэлэгийн цахим системийн программ-д өвчний түүхийг бичнэ.
  - 15:00 цагаас өмнө үзлэгт хэрэглэсэн багажийг ариутгалд өгнө.
  - 16:00 цагт үзлэгийг дуусгаад мэс засалд хэрэглэгдэх материалыг бэлтгэж ариутгалд өгнө.

Мэс засал хариуцан ажиллах резидент эмч:

8:30 ~ 17:00

- Мэс засалд өдөр бүр 2 резидент байна. 1 нь мэс засалд assistant, 1 нь туслах ажил хийнэ.
- Мэс засал эхлэхээс 30 минутын өмнө багшаас түрүүлж хагалгааны өрөөнд ороод үйлчлүүлэгчийг мэс засалд бэлдэж мэс заслын багаж тоног төхөөрөмжийг шалгана.
- Өвчний түүх нээнэ. Мэс заслын тухай зөвлөгөө, мэдээлэл өгнө.
- Хамрын мэс засалд орох өвчтөний 'olfactory function test' хийгээд протоколыг бичнэ.
- Мэс засал хийхэд өвчтөнийг бэлтгэнэ: хамрын үс авах, адриналин: лидокаин 1:100.000 тариа хийх, cotton bar хийх /assistant/.
- Мэс засал хийхэд багшид тусална /assistant/.
- Багшийн заавраар, багшийн хяналтан дор мэс засал хийнэ /assistant/.

- Мэс заслын дараа өвчтөнийг 2 цагийн турш сэрээх өрөөнд хянаж, тасагт шилжүүлнэ /туслах/.
- Мэс заслын тэмдэглэл бичнэ /assistant/. Бичсэн тэмдэглэлийг багшаар хянуулаад гарын үсэг зуруулна.
- Тасагт байгаа өвчтөнийг үзэж, өдөр тутам түүхэнд тэмдэглэл бичнэ /assistant/. Багшаар хянуулаад гарын үсэг зуруулна.
- Өвчтөнийг эмнэлэгээс гарахад зөвлөгөө өгөх ба эмчилгээний зардлыг төлүүлнэ. Амралтын өдөр гарах бол тухайн долоо хоногийн баасан гаригт төлбөрийг хийлгэнэ.
- Хамрын мэс засалд орсон өвчтөний хамрын өмнөд чихээсийг авна /assistant/.
- Амралтын өдөр хамрын чихээс авах, өвчтөн үзэх бол assistant ба туслах ээлжлэн үдээс өмнө ирнэ (10-11цагт).
- Чихээс авсанаас хойш 7 хоногийн турш өвчтөнийг хянана /assistant/.
- Тухайн өдөр мэс засал байхгүй бол үзлэгт туслах; багшид мэдэгдээд номын санд сууж болно.
- Багшийн зөвшөөрөлгүй эмнэлэг, сургуулийг орхин явахыг хориглоно.

#### Сургалтын үйл ажиллагаа хариуцсан резидент эмч:

7:40 ~ 17:30

- Сургалтанд 1-2 резидент ажиллана.
- Лекц, дадлага, семинарийн бүх хичээлд, бүх багш нарт тусална.
- 7 хоног бүрийн Пүрэв гариг бүрт хичээлийн хуваарийг сургалтын албанд явуулж хичээл орох ангийг хувиарлуулаад хуваарийг тэнхмийн самбарт тавина. Хуваарийг тэнхмийн эрхлэгчид e-мейлээр илгээнэ.
- Хичээл эхлэхээс 30 минутын өмнө хичээл заах багштай уулзаж тухайн хичээлд онцгой хэрэгтэй зүйлийн талаар асууж бэлтгэлийг хангана.
- Хичээлийн өрөөний багаж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж бэлтгэсэн байна.
  - Computer
  - Дэлгэц /байхгүй бол /Projector/
  - HDMI
  - Дадлагад хэрэглэх үзлэгийн багаж /хамрын толь, чихний толь, хэл дарагч, духны толь, хажуугийн гэрэл, спирт, хөвөн, камертон/
- Хичээлээс 10 минутын өмнө ангид оюутнуудыг оруулж ирц бүртгэнэ.
- Лекцийн ирцийг бүртгэж, лекцтасалсан оюутны нэр, ангийг тэмдэглэн дадлага удирдсан багшид өгнө.
- Зарим гардан үйлдлийг оюутанд заана. Гардан үйлдлийг шалгаж дүгнэнэ. Үүнд:
  - Хамрын өмнөд ба арын тольдолт
  - Ам залгиурын үзлэг
  - Шууд ба шууд бус аргаар төвөнх дурандах
  - Камертон ашиглан сонсголын тестүүд хийх
  - Тэнцвэрийн тестүүд хийх

- Хичээл нь үзлэг, мэс засалтай давхацсан бол хэсгийн ахлагчтай зөвлөлдөн цагийг зохицуулж багшид мэдэгдэнэ.
- Оюутнууд мэс заслын өрөөнд орох шаардлагатай үед халдвар хамгааллыг сахиулж, 1 удаагийн халат, мэс заслын бүрэн хувцастай эсэхийг шалгана. Мэс заслын өрөөд орох цагийг товлож, багштай ярьж зохицуулна.
- Үзлэгийн өрөө, үзлэгийн багаж, station-ы талаар тайлбарлана.
- Үзлэгийн өрөөнд багш үзлэг хийж зөвлөгөө өгч буйг оюутанд харуулах ба тайлбарлана.
- Үзлэгийн өрөө ба ур чадварын өрөөнд /206 тоот/ гардан үйлдэл зааж өгөх ба оюутнуудаар үзлэг хийлгэнэ.
- Тухайн өдөр хичээл байхгүй бол мэс засал, үзлэгт туслах ба багшийн зөвшөөрлөөр номын санд сууж болно.
- Багшийн зөвшөөрөлгүй эмнэлэг, сургуулийг орхин явахыг хориглоно.

## Семинарын хичээлийн тайлан

Резидент эмч: \_\_\_\_\_

.....он.....сар.....өдөр

№	Хичээл	1-р долоо хоног			2-р долоо хоног			3-р долоо хоног			4-р долоо хоног			5-р долоо хоног		
		Ирсэн	Бэлдсэн	Үнэлгээ												
	Сэтгүүлийн тойм															
	Сэдэв															
	Сурах бичгийн сэдвүүдийн үндсэн хэлэлцүүлэг															
	Сэдэв															
	Тохиолдлын хэлэлцүүлэг															
	Сэдэв															
	Тэнхмийн лекц															
4	Сэдэв															
	Бусад															
	Багшийн гарын үсэг															
Бэлдэх ёстой:								Бэлдсэн:								

Тайлан бичсэн: Резидент эмч:

/...../

Хянасан: Зохицуулагч багш:

/...../

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ  
(DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

..... он ..... сар .....

Суралцагч эмчийн нэр ..... Үнэлэгчийн нэр .....

Сургалт эрхлэх байгууллага: ..... нэгж .....

	№	Practice	1-р долоо хоног		2-р долоо хоног		3-р долоо хоног		4-р долоо хоног		5-р долоо хоног		Бүгд	
			Тоо											
			Хийсэн	Харсан	Хийсэн	Харсан								
Чих хамар хоолойн ерэнхий үйл ажиллагаа	1	Үйлчлүүлэгчид чих хамар хоолойн ерөнхий үзлэг хийх												
	2	Үйлчлүүлэгчийн чих хамар хоолойн ерөнхий үзлэгийн багаж тоног төхөөрөмжийг бэлтгэх												
	3	Үйлчлүүлэгчийн карт бичих												
	4	Үйлчлүүлэгчийн шинжилгээ, эмчилгээг төлөвлөх												
	5	Үйлчлүүлэгчийг мэс ажилбарт бэлтгэх												
	6	Үйлчлүүлэгчийн өвчний түүхийг нээх												
Чих	1	Гадна чихний сувгийн хатгийг оношлох, эмчлэх												
	2	Нэвчүүлж хэсгийн мэдээгүйжүүлэг хийх												
	3	Гадна чихний сувгаас гадны биетийг авах												
	4	Гадна чихний цусан хурааг нээх												
	5	Сонсгол шалгах												
	6	Тэнцвэр шалгах												
	7	Гэнэтийн дүлийрэлт, толгой эргэлт, нүүрний саажилт, чих шуугилтыг оношлох, эмчлэх												
	8	Хэнгэргэн хальсанд даралт тэнцвэржүүлэх гуурс байрлуулах												
	9	Гадна чихний сувгаас эдийн шинжилгээ авах												
	10	Хэнгэрэг нөхөх мэс засалд орсон өвчтөний хагалгааны дараах хяналт, асаргаа, сувилгааг хийх												

	11	Чих орчмын төрөлхийн сүв авах мэс засал хийх, мэс засалд оролцох																		
	12	Хэнгэрэг нөхөх мэс засал /багшийн хяналтанд/																		
	13	Хөхлөг сэртэнг нээх мэс засал /багшийн хяналтанд/																		
	14	I-III хэлбэрийн хэнгэрэг нөхөх мэс засал																		
	15	Сувгийн ар ханыг буулгах хөхлөг сэртэнг нээх мэс засал /багшийн хяналтанд/																		
Хамар	1	Хамарт хэсгийн мэдээгүйжүүлэг хийх																		
	2	Хамрыг хөндийг дурангаар шинжлэх																		
	3	Хамрын хөндийгөөс гадны биетийг авах																		
	4	Хагалгааны дараа хамрын хөндийг дурангаар цэвэрлэх, хянах																		
	5	Харшлын ба харшлын бус риниттэй хүнд эмчилгээний төлөвлөгөө боловсруулах																		
	6	Таславч тэгшлэх, доод самалдгийн багасгах мэс заслын дараах хяналтыг хийх																		
	7	Хамрын цус тогтоох																		
	8	Хамрын шинэ хугарлыг засах																		
	9	Зажуурын хөндийг нээх																		
	10	Хамрын хөндийгөөс ур авах																		
	11	Хамрын таславч самалдгийн мэс засалд туслах ба багшийн хяналтанд хийх																		
	12	Хамрын хөндий болон давар хөндийнүүдийн дурангийн мэс засалд туслах ба багшийн хяналтанд хийх																		
	13	Хамрын нөхөн сэргээх мэс засалд туслах ба багшийн хяналтанд хийх																		
	14																			
Төвөнх ба толгой хүзүүний мэс засал	1	Төвөнхийг шууд дурандалтаар шинжлэх																		
	2	Арьсанд төрөл бүрийн техникээр оёдол тавих																		
	3	Мэс заслын зангилаануудыг хийж гүйцэтгэх /чих хамар хоолойн тасгийн дадлага/																		
	4	Амны хөндийгөөс эдийн шинжилгээ авах																		
	5	Хөөмийн гүйлс орчмын буглааг нээх																		

6	Нармай болон тагнай гүйлсэн булчирхайн мэс заслын дараахь хяналтыг хийх																		
7	Төвөнхийн хоргүй ба хавдар төст үүсгэврүүдийг оношлох, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах																		
8	Арьсан доорхи эдийн гэмтлийн үед оёдол тавих, шарх цэгцлэх																		
9	Z-plasty, W-plasty гм гоо сайхны оёдол тавих																		
10	Нармай болон тагнай гүйлсэн булчирхайн мэс засал хийх																		
11	Френотомии мэс заслыг хийх																		
12	Хүзүүний тунгалгийн булчирхайг зүсч эдийн шинжилгээ авах																		
13	Өвчтөний амьсгалын замыг үнэлэх																		
14	Цагаан мөгөөрсөн хллойг зүсч гуурс тавих																		
15	Шүлсний булчирхайгаас чулуу авах																		
16	Багшийн хяналтанд төвөнхийн хөндийн бичил мэс засал хийх																		
17	Багшийн хяналтанд эрүүн доорхи булчирхайд зүслэг, мэс засал хийх																		

Резидент эмчийн нэр: \_\_\_\_\_

## 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр ..... он ..... сар .....

Үнэлгээ хийгч: ( ) эмнэл зүйн сургагч багш ( ) сувилагч ( ) бусад

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийн ажигласнаар оноо тавина уу.

Тухайн асуултанд үнэлгээ авах боломжгүй бол 0

Тухайн асуултыг 19% биелүүлсэн бол 1;

20-49% биелүүлсэн бол 2 ;

50-79 % биелүүлсэн бол 3;

80%-аас дээш биелүүлсэн бол 4 гэсэн үнэлгээ өгнө

№	Үнэлэх үзүүлэлт	Дүн				
		0	1	2	3	4
1	Үйлчлүүлэгч, гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	0	1	2	3	4
2	Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт гаргацтай цаг хугацаанд хөтөлдөг	0	1	2	3	4
3	Үйлчлэх хүрээний болон орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг	0	1	2	3	4
4	Өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэр гаргахыг хичээн зүтгэл гаргадаг	0	1	2	3	4
5	Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг	0	1	2	3	4
6	Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт, бусад боломжийг алдалгүй ашигладаг	0	1	2	3	4
7	Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг	0	1	2	3	4
8	Бусад эмнэлгийн эмч мэргэжилтэнтэй хамтран ажилладаг	0	1	2	3	4
9	Эмнэлэг доторх эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг	0	1	2	3	4
10	Ажиллаж байгаа эмнэлгийн доторх тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	0	1	2	3	4
11	Үйлчлэх хүрээний болон орон нутгийн тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	0	1	2	3	4

**1 эсвэл 4 оноо өгсөн бол шалтгаанаа бичнэ үү**

- 1.
- 2.
- 3.

## ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... он ..... сар .....

Суралцагч эмчийн нэр ..... Үнэлэгчийн нэр .....

Сургалт эрхлэгч байгууллага: ..... нэгж .....

Өвчтний нас ..... эр эм

## Өвчтөний зовиур: Шинж тэмдэг (signs and symptoms)

1. Хамар битүүрэх, 2. Хамраас нус гоожих 3. Нүүр чинэрч өвдөх 4. Толгой өвдөх 5. Халуурах 6. Хамраас залгиур руу нус урсаж орох 7. Хамрын хөндий хуурайших 8. Хамарт шархлаа үүсэх 9. Хамраас цус гарах 10. Найтаах 11. Хоолой хөндүүрлэх, 12. Хоолой хатах, хуурайших 13. Хоолой сэрвэгнэх 14. Дуу гунших 15. Хоолой сөөх 16. Амьсгал бачуурах 17. Чих хатгаж өвдөх 18. Чих загатнах 19. Чихнээс булаг гарах чих шуугих 20. Дүлийрэх

Сургалтын явцад суралцагч эмч ямар түвшинд байгааг өөрийн ажигласнаар дүгнэнэ үү				
№	Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
1	Өвчний өгүүлэмж авах			
2	Бодит үзлэг			
3	Оношилгоо эмчилгээний менежмент			
4	Харилцааны ур чадвар			
5	Эмнэл зүйн ерөнхий чадвар			
Сайн талууд		Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал	

## Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

--

Үнэлэгчийн гарын үсэг ..... Суралцагчийн гарын үсэг .....

## “Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд

Өвчний өгүүлэмж авах	Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Оношилгоо эмчилгээний менежмент	Зөв онош тавьдаг Оношилгоо эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг Тохирсон эмчилгээ эхлүүлдэг Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч хүнийг сайн сонсдог Тэдний зовиолыг хуваалцаж хүндэтгэлтэй ханддаг Тэдэнтэй эелдэг харилцаж, энгийн үг хэллэг хэрэглэн зөвлөгөө өгдөг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	Системтэй, харицан уялдаатай арга замыг сонгодог Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг. “Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна.”

## Тойролт хариуцсан багшийн үнэлгээ

№	Оноо	Маш сайн /3 оноо/	Хангалттай /2 оноо/	Хангалтгүй /1 оноо/
1	Мэдлэг			
2	Эмнэлгийн менежмент			
3	Ном сурах бичиг ашиглах чадвар			
4	Идэвхи, оролцоо			
5	Асуумж, бодит үзлэг хийх чадвар			
6	Ялган оношлогооны ур чадвар			
7	Өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээ			
8	Хариуцлага, харилцаа, хүндэтгэл			
9	Мэргэжлийн үнэ цэнэ			
10	Нийт оноо /27/			
11	Нийт оноо, хувиар /100%/			

Тайлан бичсэн:

Резидент: .....

Хянасан:

Тойролт хариуцсан багш: .....

Зохицуулагч багш: .....

## Ажиглан дүгнэх шалгалтын хуудас

Суралцагчийн ..... Овог ..... Нэр

Сургалтын нэр: .....

Сургалтын хугацаа: .....

Сургалт эхэлсэн он сар өдөр: .....

Сургалт дууссан он сар өдөр: .....

Сургалт удирдсан багш: .....

№	Үнэлгээний шалгуурууд	Рейтинг оноо (0-100)	Авсан рейтинг оноо (0-100)
1.	<ul style="list-style-type: none"> <li>- Харилцааны ур чадвар</li> <li>- Бодит үзлэг</li> <li>- Үзэх шинжилгээ</li> <li>- Хүрэлцэх шинжилгээ</li> <li>- Асууж ярилцах</li> <li>- Дэс дараалал, эв дүй</li> <li>- Эмгэг шинжийг илрүүлэх байдал</li> </ul>	30	
2.	<ul style="list-style-type: none"> <li>- Шинжилгээг үнэлэх</li> <li>- Оношлох, ялган оношлох</li> <li>- Эмчилгээний төлөвлөгөө</li> </ul>	30	
3.	<ul style="list-style-type: none"> <li>- Хийж үзүүлэх ур чадвар</li> <li>- Зөвөлгөө өгөх ур чадвар</li> <li>- Гэр бүл хамт олонтой харьцах чадвар</li> <li>- Урьдчилан сэргийлэх зөвлөгөө</li> </ul>	20	
4.	<ul style="list-style-type: none"> <li>- Анхаарал халамж</li> <li>- Тайлбарлах чадвар</li> <li>- Үгийн нийцэмж</li> </ul>	20	
5.	Дундаж рейтинг	100	

Шалгалтын комисс:

1. .... / /

2. .... / /

3. .... / /

4. .... / /

## ЧИХ ХАМАР ХООЛОЙН ЭМЧИЙН РЕЗИДЭНТ СУРГАЛТААР ЭЗЭМШИХ ХАНДЛАГЫН ЦОГЦ ЧАДАМЖ

<b>Үйлчлүүлэгч эсвэл бусад эх сурвалжаас үнэн зөв, товч тодорхой, чухал хамааралтай мэдээллийг асууж цуглуулах чадварууд :</b>		
	Үнэлгээ	
	ХАНГАЛТТАЙ	ХАНГАЛТГҮЙ
Үйлчлүүлэгч түүний ар гэрийнхэн , асран хамгаалагчтай харилцаж , өвчний түүх бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулах байдлаар эрүүл ба эмгэг байдлыг тодруулах		
Үйлчлүүлэгчтэй ярилцаж биеийн болон сэтгэцийн зовиур ,шинж тэмдэг ,биеийн ерөнхий байдал ,тухайн өвчний талаарх ойлголт , сэтгэл зовинол ,нийгэм , соёл ,ёс заншил ,үйлчлүүлэгчийн хүлээж буй найдлага ,санал хүсэлтийг тодорхойлох		
Ярилцлагын төгсгөлд үйлчлүүлэгчид илэрч буй шинж тэмдэг ,зовиур шаналгааны талаар үнэн зөв мэдлэг олгох		
Эмч хийх гэж буй үйлдлийнхээ талаар үйлчлүүлэгчид тайлбарлаж зөвшөөрөл авч түүний тав тухтай байдлыг хангах		
Эмнэлзүйн үзлэгийг ур чадвартайгаар хийж ,үйлчлүүлэгчтэй хүндэтгэлтэй харилцах		
Үйлчлүүлэгчид илэрч буй шинж тэмдэг ,нэмэлт асуумжинд тулгуурлан таамаглаж буй оношинд тохирох нарийвчилсан үзлэг хийх		
Цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж ,яаралтай тусламж хэрэгтэй эсэхийг шийдвэрлэх ,ялган оношлох ,оношийн үндэслэл тавьж үзүүлэх тусламжийн шатлалыг тодорхойлох		
Оношилгоо хийхдээ үйлчлүүлэгчийн ар гэр ,нийгэм ,ёс заншил ,шашин шүтлэг ,овун санааны болон бусад холбоо хамааралтай байдлыг харгалзан үзэх		
Цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан оношилгоо эмчилгээний цаашдын төлөвлөгөө зохиож эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдээс зөвлөгөө тусламж хүсэх , хэлээх тактикийг баримтлах		
Аливаа эмгэгийн шинж ,хамшинж түүнтэй холбоотой цуглуулсан эмнэлзүйн мэдээллийн эерэг ,сөрөг төлөөлөх утгыг мэдэж ,тэдгээр нь тухайн өвчний тархалтаас хамаардаг болохыг анхааран үзэх		
Эмч нь Эмнэлзүйн чадвар-ын хэсэгт заасны дагуу оношилгоо эмчилгээний үйлдлийг хийж гүйцэтгэх		

Үйлчлүүлэгчид ямар нэгэн шинжилгээ, ажилбар гүйцэтгэхийн өмнө ажилбарын ач холбогдолтой болон эрсдэлт талыг нь үнэлэх		
Үйлчлүүлэгчид цаашид хийгдэх шинжилгээ, ажилбарын талаар болон түүний ач холбогдол эрсдэлийг тайлбарлах		
Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээтэй холбогдох мэдээллийг нэгтгэн дүгнэх, эмчилгээ, оношилгооны талаар шийдвэр гаргах, цаашдын төлөвлөгөөний талаар танилцуулах, дагалдаж буй эмч болон эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдэд товч тодорхой танилцуулах, тэдний саналыг авах		
Өвчний түүх, гардан үйлдэл, шинжилгээ, менежментийн төлөвлөгөөний талаарх тайланг үнэн зөв, логикийн дагуу, иж бүрэн, зохих ёсоор системтэйгээр, цаг хугацааг оруулан үйлчлүүлэгчуншихад гаргацтай байдлаар өөрөө тэмдэглэж өгөх		
Тэмдэглэлээ сайн хөтлөх, мэдээллийн нууцыг хадгалах нь анагаах ухаан болон хууль зүйн чухал ач холбогдолтой болохыг ухамсарлах		
Эмч нь өвчний үе шат, үр дагавар, төгсгөлийн талаарх мэдээллийг үнэн зөв тайлагнах		
Хүний бүтэц үйл ажиллагааг молекулын төвшнөөс нийгэм дэх хувь хүн хүртэлх, хэвийн бүтцээс эмгэг байдал үүсэх хүртэлх хөгжлийн бүхий л үе шатуудад нь тайлбарлаж мэддэг байх		
Анагаах ухааны үндэс, анагаах ухааны ирээдүйн чиг баримжаа тэдгээрийн нийгэм дэх ойлголт, түүхэн хөгжлийн талаар мэддэг байх		
Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн талаар орчин үеийн анагаах ухааны нотолгоо, яаралтай арга хэмжээг мэддэг байх		
Өдөр тутмын оношилгоо эмчилгээндээ өөрийн мэдлэгээ зориулж яаралтай арга хэмжээ авч гүйцэтгэх		
Үйлчлүүлэгч түүний ар гэр бусад холбогдох хүмүүст дэлгэрэнгүй түргэн шуурхай мэдээлэл өгч зөвшилцөхөд нь дэмжиж шийдвэр гаргахад нь оролцох		
Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал болон үйлчлүүлэгчийн шилжүүлэх үеийн мэдээлэлд ач холбогдол өгч анхаарлаа хандуулах		
Үйлчлүүлэгчтэй ярилцах санал бодлоо илэрхийлэх, асуулт асуух хангалттай цаг гаргаж идэвхитэй сонсох		
Үйлчлүүлэгчийн асуултанд хариулт өгөх боломжгүй тохиолдолд тусламж зөвлөгөө түргэн шуурхай хайх		
Үйлчлүүлэгчийн сонголтыг дэмжих		
Үйлчлүүлэгчийн нийгэм, соёлын онцлогийг эмнэлзүйн ажилдаа харгалзан ажилладаг байх		
Үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүд хамт олонд нь өвчний гарч болзошгүй үр дагаврын талаар танилцуулах		
Эмнэлгийн бичиг баримтанд үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авахдаа түүнд танилцуулагдах шаардлагатай бүхий л чухал мэдээллийг тодорхойлох ба үйлчлүүлэгчийн эмчилгээнээс татгалзах эрхийг нь хүндэтгэх		
Эмч нь эмзэг бүлгийн үйлчлүүлэгчтэй /хүүхэд, өндөр настан, хүнд өвчтэй / анхаарал болгоомжтой хандах		

Үйлчлүүлэгчийн хүсэлт сонирхол ,өвчний хүндийн зэрэг,архаг болон хавсарсан өвчнүүдийг харгалзан тохиромжтой, зөв зүйтэй шийдвэр гаргах		
Эмч нь үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалах		
Амилуулах оролдогыг зогсоох асуудлыг хэлэлцэх шалгуур үзүүлэлт болон шаардагдах зэрэглэлийг тайлбарлах		
Өөрийн мэргэшлийн дутагдалтай байдлбг хүлээн зөвшөөрч үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээнд бусдын тусламжийг авах		
Тусламж үйлчилгээнд алдаа гарсан үед зохих журмын дагуу ажиллах		
Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний талаарх сэтгэл хангамжийн байдалд мэдрэмжтэй хандаж ,шаардлагатай нөхцөл байдлыг эрэлхийлэх		
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний алдаа эндэгдлийг илрүүлэх алдааг арилгах		
Эм бэлдмэл ,шингэн цус цусан бүтээгдэхүүний жорыг зөв тодорхой хоёрдмол утгагүйгээр бичиж огноо гаргацтай гарын үсгээр баталгаажуулах		
Жор бичихдээ эмийн үнийг харгалзан үзэх		
Хүүхэд , өндөр настан ,жирэмсэн болон хөхүүл эх ,элэг бөөр,зүрхний үйл ажиллагааны дутагдалтай үйлчлүүлэгчид аюулгүй жор бичих зарчмыг ашиглах		
Өвдөлт намдаах , хөнгөвчлөх амьдралын төгсгөлийн шатны эмчилгээний зарчмыг тайлбарлах		
Эмийн харилцан үйлчлэлийг мэддэг гарч болох урвалыг багасгах хангалттай мэдлэгтэй байх		
Эмчилгээний явц үр дүнг хянан ,эмчилгээг дагаж мөрдөж байгаа үйлчлүүлэгчийн урамшуулж эмчилгээ эмийн тунг тохируулах		
Эмчилгээнд үр дүнгүй байгаа үйлчлүүлэгчийн илрүүлэн үохих арга хэмжээг цаг алдалгүй авах		
Эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд эмийн хяналтын холбогдох байгууллагад мэдэгдэх		
Эмчилгээ ,ажилбараас хүндрэл ,гаж нөлөө гарч болохыг ойлгож үйлчлүүлэгчийн мэдээлэл анхааруулга зааварчилгаагаар хангах		
Эмийн жорын аюулгүй байдлыг хангах		
Халдвараас сэргийлэх зарчим халдварын эх үүсгэврийг тодорхойлох		
Хувь хүний зан үйл эрүүл ахиугаас үүдэн халдвар дамжих эрсдлийг багасгах		
Хувийн эрүүл мэндийн асуудлаас шалтгаалан үйлчлүүлэгчид халдварын эрсдэл учруулахаас сэргийлэх		
Өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх		
Үйлчлүүлэгчид хоололт ,шим тэжээл ,тамхидалд,архидалт ,эмийн зохисгүй хэрэглээ гэх мэт амьдралын буруу хэв маяг эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар зөвлөгөө өгөх		

Эрт илрүүлгийн сорил ,дархлаажуулалтыг тохиромжтой байдлаар санал болгох		
Үйлчлүүлэгчийн зовиураас эхлэн эмнэлзүйн зохих асуултыг тавьж тохиромжтой мэдээллийн эх сурвалжийг ашиглан үр дүнтэйгээр хайлт хийх		
Холбогдох нотолгоог олж авах тухайн нотолгооныхоо чанарыг олон эх сурвалжийг ашиглан батлах түүндээ тулгуурлан мэргэжлийн эмчийн хяналтан дор үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээтэй холбоотой дүгнэлтийг хийх		
Эмч нь сайн харилцаа бол үйлчлүүлэгч эмчийн сэтгэл хангамж эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэх эмнэлзүйн үндсэн ур чадвар болохыг мэддэг байх		
Аман бус биеийн өгүүлэмж үйлчлүүлэгчид тодорхой сэтгэгдэл төрүүлдэг болохыг ойлгож түүний зөв ашиглах		
Таагүй мэдээг хүргэх үедээ шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх тохиромжтой хэрэгслийг сонгож чаддаг байх		
Ууртай эсвэл сэтгэл ханамжгүй үйлчлүүлэгч түүний гэр бүлтэй харилцахдаа туршлагатай эмч нарын тусламжийг зохистойгоор авах		
Хэл ярианы бэрхшээлтэй ,хэл ярианы хөгжил муутай үйлчлүүлэгчтэй харилцахдаа тусламж авах		
Үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлох асуудлыг тодорхой тайлбарлах ойлгоцыг шалгах		
Үйлчлүүлэгчтэй харилцахдаа тохиромжтой зайг баримтлах ,сэтгэл санааны хувиарлаа тодорхой түвшинд барьж чаддаг байх		
Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэн асран хамгаалагчтай харилцаж өвчний түүх болон эх сурвалжаас мэдээлэл цуглуулах байдлаар эрүүл ба эмгэг байдлыг тодорхойлох.		
Үйлчлүүлэгчтэй ярилцаж биеийн болон сэтгэцийн зовиур шинж тэмдэг биеийн ерөнхий байдал, тухайн өвчний талаархи ойлголт, сэтгэл зовиол, нийгэм соёлын ёс заншил, үйлчлүүлэгчийн хүлээж буй найдлага, түүний санал хүсэлтийг тодорхойлох.		
Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээн дэхь нийгэм гэр бүлийн байдалд хүндэтгэлтэйгээр бодитой хандах.		
Үйлчлүүлэгч түүний ар гэр, хамтран ажиллагсад, бусад мэргэжилтэнүүдэд дэлгэрэнгүй, түргэн шуурхай мэдээлж, зөвшилцөхөд нь дэмжиж, шийдвэр гаргахад нь оролцох.		
Хүнд өвчтэй ухаангүй үйлчлүүлэгчийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх хэрэв ар гэрийн хүн байхгүй тохиолдолд бусад холбогдох хүмүүст мэдээлэх.		
Үйлчлүүлэгчид цаашид хийгдэх шинжилгээ, ажилбарын ач холбогдол, эрсдэлийг тайлбарлах.		
Үйлчлүүлэгчтэй ярилцах, санал бодлоо илэрхийлэх, асуулт асуух хангалттай цаг гаргаж, идэвхитэй сонсох.		
Эмзэг бүлгийн өвчинүүдтэй /хүүхэд хүнд болон амьдралын төгсгөлийн шатанд байгаа болон сэтгэцийн өвчтэй үйлчлүүлэгч/ харилцахдаа гойд анхааралтай хандах.		
Үйлчлүүлэгчийн эмнэлэгт хандах болон шалтгаан бие махбодь, сэтгэл санааны зан төлөвийн асуудалыг илрүүлэх.		

Үйлчлүүлэгчид хооллолт, шим тэжээл, тамхидалт, архидхлт, зохисгүй хэрэглээ гэх мэт амьдралын хэв маяг эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар тохиромжтой зөвлөгөө өгөх.		
Үйлчлүүлэгчийн асуудал тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах талаар нэгдсэн ойлголттой болохын тулд багийн бүх гишүүдтэй үр дүнтэй байдлаар харицах		
Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээтэй холбогдох мэдээлэлийг нэгтгэн дүгнэх эмчилгээ оношлогооны шийдвэр, цаашдын төлөвлөгөөний талаар танилцуулах. Нарийн мэргэжилийн эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдэд товч тодорхой танилцуулах, тэдний саналыг авах.		
Өвчний түүх гардан үйлдэл, шинжилгээ, менежментийн төлөвлөгөөний талаархи тайланг үнэн зөв, логикийн дагуу иж бүрэн зохих ёсоор, системтэйгээр цаг хугацааг оруулан, үйлчлүүлэгч уншихад гаргацтай байдлаар өөрөө бичиж тэмдэглэх.		
Эмч нь өвчний үе ша, үр дагавар төгсгөлийн талаархи мэдээлэлийг үнэн зөв тайлагнах.		
Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээтэй холбогдох мэдээллийг нэгтгэн дүгнэх, эмчилгээ ,оношилгооны шийдвэр ,цаашдын төлөвлөгөөний талаар танилцуулах ,нарийн мэргэжлийн эмч ,эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдэд товч тодорхой танилцуулах,тэдний саналыг авах		
Эмч нартай үйлчлүүлэгчийн эмчилгээний сонголт түүнтэй холбоотой эрсдэл болон давуу талыг хэлэлцэх		
Өөрийн мэргэжлийн дутагдалтай байдлыг хүлээн зөвшөөрч .Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээнд бусдын тусламжийг авах		
Үйлчлүүлэгчийн асуудал ,тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах талаар нэгдсэн ойлголттой болохын тулд багийн бүх гишүүдтэй үр дүнтэй байдлаар харилцах		
Амрах ,эзгүй үедээ үйлчлүүлэгчийн онош ,яаралтай асуудлууд эмчилгээ ,үйлчилгээний цаашидын төлөвлөгөөний талаарх үндсэн мэдээллийг тодорхой үлдээж ,тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах		
Ахмад ,эзгүй үедээ үйлчлүүлэгчийн онош яаралтай асуудлууд эмчилгээ ,үйлчилгээний цаашдын төлөвлөгөөний талаарх үндсэн мэдээллийг тодорхой үлдээж тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах		
Үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал болон үйлчлүүлэгчийг шилжүүлэх үеийн мэдээлэлд ач холбогдол өгч анхаарал хандуулах		
Өвчтөнөөс болон эмч нараас өөрийн ажлын чанартай холбоотой санал хүсэх ,ирсэн саналыг хүлээн авах /сөрөг санал/		
Багийн үйл ажиллагаанд хувийн үүрэг хариуцлагаа хүлээж ажиллах		
Өөрийн үйлчлүүлэгчийн хяналтын талаар сувилагчид зааж хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх		
Эмнэлзүйн шийдвэр гаргах ,тусламж үйлчилгээний суурь нотолгооны талаар хамтран ажиллагсад бусад мэргэжилтнүүдтэй хэлэлцэх боломжийг эрэлхийлэх		

Салбар дундын хамтын ажиллагаа, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хувь хүний төдийгүй нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хариуцлагыг хамтран хүлээх		
Өөрийн сургалтын хэрэгцээгээ тогтмол үнэлж, хамрагдах сургалтаа төлөвлөн суралцах.		
Хамрагдсан сургалтынхаа төгсгөлд үр дүнг тооцон эзэмшсэн шинэ чадваруудаа эмнэл зүйн ажилдаа хэрэгжүүлдэг байна.		
Анагаах ухааны судалгаа шинжилгээний ерөнхий зарчим арга зүйг мэддэг, цаг хугацаа өнгөрөхөд тэрхүү зарчим, аргачлал нь өөрчлөгддөг болохыг ойлгох.		
Шинжлэх ухаанч асуулт тавих ерөнхий зарчим, биостатистикийн үндэсийг мэддэг байх.		
Анагаах ухааны үндэс, орчин үеийн анагаах ухааны хөгжлийн чиг баримжаа, тэдгээрийн нийгэм дэх ойлголт болон түүхэн хөгжлийн талаар мэддэг байх		
Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн талаар орчин үеийн анагаах ухааны нотолгоо, яаралтай арга хэмжээг мэддэг байх		
Үйлчлүүлэгчийн зовиураас эхлэнэмнэлзүйн зохих асуултыг тавьж, тохиромжтой мэдээлийн эх сурвалжийг ашиглан үр дүнтэйгээр хайлт хийх		
Холбогдох нотолгоог олж авах, тухайн нотолгооныхоо чанарыг олон эх сурвалжийг ашиглан батлах, түүн дээр тулгуурлан мэргэжлийн эмчийн хяналтан дор үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээтэй холбоотой дүгнэлтийг хийх		
Эмнэлзүйн шийдвэр гаргах, тусламж үйлчилгээний суурь нотолгооны талаар хамран ажиллагсад бусад мэргэжилтнүүдтэй хэлэлцэх боломжийг эрэлхийлэх		
Орон нутгийн болон үндэсний хэмжээний, стандарт эмнэлзүйн удирдамжийг өөрийн ажилдаа бүтээлчээр ашиглах		
Эмнэлзүйн тулгарсан асуудалд төгс шийдвэр гаргах шаардлагатай болохыг ойлгодог байх		
Эмч нар, оюутанууд, эмнэлгийн бусад мэргэжилтэнд хичээл заах		
Сургалтын дараа үнэлгээ хийж, үр дүнг бүтээлчээр танилцуулах		
Судалгааны төсөл бичих, төсөл удирдах, хамтарсан төсөлт ажилд оролцох, эрдэм судаллын ажил хийж өөрийгөө хөгжүүлэх		
Шинэ мэдлэгийг хамтран ажиллагсад, бусад харилцагчдаа түгээх, өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэх		
Мэдлэг чадвар, мэргэжлийн зан төлөвөө тохиромжтой түвшинд барьж сайжруулах		
Тусламж үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх нийгэм, соёл, шашны асуудлуудыг ухамсарлах		
Өөрчлөгдөн буй эмчийн үүрэг үйлчлүүлэгч, нийгэм хэрхэн хандаж байсан түүхийг анхаарч үздэг байх		
Үйлчлүүлэгчийн эмгэг байдал, авч байсан тусламж үйлчилгээнүүд болон эрүүл мэндийн байгууллагуудтай харилцааж байсан харилцааны талаар өмнөх дурдатгалыг анхаарах		
Үйлчлүүлэгч, үйлчлүүлэгсдийн эрхийг мэддэг, хүндэлдэг байх		

Эмгэг байдал нь үйлчлүүлэгчийн хараат бус байдал, нэр хүндэд нөлөөлж болохыг ойлгодог байх		
Эмнэлзүйн шийдвэр гаргахдаа үйлчлүүлэгчийн хүсэлт, сонголт хамгийн чухал болохыг мэддэг байх		
Мэргэжлийн үйл ажиллагааны стандартууд, хууль тогтоомжоор үйлчлүүлэгчийн нууцлалын зарчим, хязгаарлалт тодорхойлогддог болохыг анхааралдаа авч, эмнэлзүйн мэдээллийг зөвхөн үйлчлүүлэгчийн зөвшөөрлөөр аман болон бичгэн хэлбэрээр бусадтай хуваалцдаг, үйлчлүүлэгчийн мэдэхгүй байх эрхийг хүндэтгэдэг байх		
Тусламж үйлчилгээ үзүүлэхдээ үнэнч, шударга, хариуцлагатай, найвдарвай, өрөвч нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр түвшинд ажиллах		
Хувийн болон мэргэжлийн үүргийн тохиромжтой харьцааг баримтлан үүсч болох ашиг сонирхлын зөрчлийн талаар ойлголттой, сэргийлж чаддаг байх		
Эмч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлаа хангах		
Эмнэлзүйн шийдвэр гаргахдаа ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах		
Ёс зүйн хэм хэмжээг сахихын ач холбогдол, ёс зүйн ба ёс суртахуун, улс төр ба хууль зүйн хоорондын ялгааг ойлгодог байх		
Өдөр тутмын ажилаа гүйцэтгэхдээ Монгол улсын эмнэлгийн ажилтны болон эмчийн ёс зүйн дүрэм, журмийг судлан танилцаж асуудал тулгарахад ашиглаж чаддаг байх		
Өдөр тутмын ажил нь мэргэжлийн дүрэм, холбогдох хуулиар зохицуулагддаг болохыг мэддэг шаардлагатай үед тэдгээрийг ашиглаж чаддаг байх		
Өдөр тутмын ажилдаа холбогдох хууль дүрмийг чандлан сахих		
Хувь хүн болон олон нийтийн эрүүл мэндийн хэрэгцээний хооронд зөрчил үүсч болох тухай ойлголттой байх		
дээшлүүлдэг, шаардлагатай тохиолдолд, ялангуяа амьдралын төгсгөлийн шатанд буй үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний асуудал хөндөгдөх үед энэ талаарх өөрийн байр сууриа илэрхийлж чаддаг байх		
Эмч анагаах ухааны ёс зүйн онолын олон талт үзэл баримтлалын талаар (контрактualист, зарчимд суурилсан, үйлчлүүлэгчийн эрхэд суурилсан, үр ашигт суурилсан, тусламжийн ёс зүйд суурилсан гэх мэт) мэддэг байх		
Бусдын зүгээс илрэх ёс зүйн асуудалд тохиромжтой шийдэлийг эрэлхийлдэг байх		
Эмч ёс бус үйл ажиллагааг тохиромжтой байдлаар даван туулах		
Эмнэлзүйд тохиолдсон нөхцөл байдал, судалгааны төсөлт ажилтай холбоотой, ёс зүйн зарчим, хэм хэмжээг болон түүнтэй холбоотой үүсэх зөрчлийг тодоройлох		
Эмч сэхээн амьдруулах үйл ажиллагааг зогсоохтой холбоотой шийдвэрийн ёс зүйн зарчмыг мэддэг байх		

Үнэлэгчийн гарын үсэг.....Суралцагчийн гарын үсэг .....